

**ЖИЛИЙН
ТАЙЛАН
2019**



Агуулга

ТУЗ-ийн даргын мэндчилгээ	5
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6

Стратегийн шинэчлэл	
2019 оны онцлох үйл явдлууд	8
Санхүүгийн гүйцэтгэл	10
Макро эдийн засгийн орчин	12
Банкны салбар	14

Манлайлах эрч хүч	
Гүйцэтгэх удирдлага	17
Төлөөлөн Удирдах Зөвлөл	18
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	19

Итгэл@Хязгааргүй	
Иргэдийн банк	20
Харилцагчаа хамгаалах зарчмууд	24
Салбарын удирдлага	25
Шагнал	25
Бизнес банк	26
Эко банк	28
Нийгмийн хариуцлага	34
Компанийн засаглал	36
Олон улсын үнэлгээ	44
Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд	45
Корреспондент банкууд	46

Дижиталчлал	
Мэдээлийн технологи, цахим аюулгүй байдал	47

Шинэ эхлэл	
Санхүүгийн үзүүлэлт	48
Эрсдэлийн удирдлага	50
Хүний нөөц	52
Дотоод аудит	58

Эрхэм зорилго

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчдадаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.

Хэтийн зорилт

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.

Бидний тухай

ХасБанк нь 2001 онд байгуулагдсан цагаасаа Монгол Улсын банк санхүүгийн системд тогтвортой өсөлтийг бий болгож, үйл ажиллагаагаа өргөтгөж ирсэн бөгөөд өдгөө системийн хэмжээний 4 том банкны нэг болоод байна. Компанийн засаглал, нийгмийн хариуцлагаараа салбартаа тэргүүлэгч ХасБанк нь Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж буй 76 салбар нэгж, 1,200 мэргэшсэн ажилтан, 5,000 гаруй мөргчонт, 350 гаруй АТМ-аар дамжуулан 1 сая харилцагчдадаа санхүүгийн цогц үйлчилгээг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан, нэр төртэйгээр хурдан шуурхай хүргэж байна.

ТУЗ-ийн даргын мэндчилгээ



Санжай Гүпта

ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд ээ,
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс ХасБанкны 2019 оны жилийн тайланг танилцуулж байгаадаа таатай байна.

Энэхүү нэр хүндтэй байгууллагыг удирдах үүрэг хариуцлагыг хүлээн авч буйдаа баяртай байгаагаа дурдах энэ дашрамд миний өмнө ХасБанкны ТУЗ-ийн даргаар 15 жил ажиллаж байгаад 2019 оны 3 дугаар сард ажлаа хүлээлгэн өгсөн Чулууны Ганболдод Банк болон ТУЗ-ийн нэрийн өмнөөс байгууллагын хөгжилд түүний оруулсан асар их хувь нэмрийг өндөр үнэлж талархал илэрхийлж байна.

ХасБанкны Гүйцэтгэх захирал Магваны Болдоо тус банканд нийтдээ 14 жил ажилласны дараа 2019 оны 5 дугаар сард ажлаа мөн хүлээлгэн өгсөн бөгөөд Банкны өсөлт хөгжилд оруулсан түүний хувь нэмрийг үнэлж талархаж байгаагаа илэрхийлье.

2019 оны 5 дугаар сард ХасБанкны шинэ Гүйцэтгэх захирлаар Гүмэнжавын Цэвэгжав томилогдсон бөгөөд өнөөг хүртэлх энэ богино хугацаанд Г.Цэвэгжав захирал Банкны үйл ажиллагааг сайжруулах талаар чухал хувь нэмэр оруулж амжаад байгааг дурдахад таатай байна. Банк цаашид түүний эрч хүчтэй манлайллын дор шинэ өсөлт амжилтад хүрч чадна гэдэгт итгэлтэй байна.

ХасБанктай нэгдмэл сонирхолтой бүх талуудад илүү сайн үйлчлэхийн тулд бид 2019 онд стратегийн олон санаачилга хэрэгжүүлсэн.

Бид өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах, харилцагчдын үйлчилгээг улам боловсронгуй болгохын тулд технологид хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, чанаргүй активыг бууруулах, хүү валютын

эрсдэлийн удирдлагыг чангатгах, үйл ажиллагааны зардлыг багасгах чиглэлээр дорвитой алхмуудыг хийж эхэлсэн.

Монголд хүчтэй эдийн засаг хэрэгтэй. Хүчтэй эдийн засагт хүчтэй банкны салбар хэрэгтэй. Бид Монголбанкнаас гаргасан, банкны салбарыг хүчтэй болгоход чиглэсэн Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих шинэ журмыг дэмжиж байгаа. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар **ХасБанкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцааг 11.9%, хөрөнгийн харьцааг 15.8%-д** хүрснийг мэдээлэхэд таатай байгаа бөгөөд эдгээр нь шинэ журмаар тогтоосон харьцаанаас 1.9% ба 3.9%-иар тус тус дээгүүр байна. Бид нэгдүгээр зэрэглэлийн хөрөнгийн харьцаагаа сайжруулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллаж, цаашид ч эдгээр харьцааг Монголбанкнаас тогтоосон түвшнээс дээгүүр байлгахад зорино.

ХасБанкны ажиллагсад амжилтын гол тулгуур юм. 2019 онд тулгарсан хүндрэлүүдийг даван туулахад манай ажилтнуудын мэргэжлийн ур чадвар чухал үүрэг гүйцэтгэсэн. Өдөр тутмын ажлыг нугалж, хүч чармайлт гарган зүтгэж ажилласан бүх ажилтнууддаа талархал дэвшүүлье.

Мөн ХасБанкны олон талын туршлагатай Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд энэ байгууллагын амжилтын эх үүсвэр юм. Банкны нэрийн өмнөөс биднийг тууштай дэмжиж, удирдамжаар чиглүүлж ирсэн та бүхэнд чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

Санжай Гүпта
ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Гүмэнжавын Цэвэгжав
Гүйцэтгэх захирал

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, хамтрагч нараа,

Юуны түрүүнд надад итгэл хүлээлгэсэн бүх хүнд энэхүү захидлаараа дамжуулан гүн талархал илэрхийлье. Гайхалтай өв уламжлал, хэтийн ирээдүйтэй онцгой байгууллагын гишүүн болсноороо би чин сэтгэлээсээ бахархаж байна. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл, ХасБанкийг удирдана гэдэг ховор завшаан бөгөөд тулгарч буй сорилт боломжуудыг миний бие гүнээ ухамсарлаж байна. Гүйцэтгэх захирлын алба нь хувьцаа эзэмшигчид, харилцагчид, ажиллагсад, хөрөнгө оруулагчид болон бүх оролцогч талуудын өмнө том хариуцлага хүлээдэг нь тодорхой.

ТСНэгдэл, ХасБанкийг Монгол Улсын системийн нэр хүндтэй банкны түвшинд хүргэхэд үлэмж их хувь нэмэр оруулсан өмнөх авьяаслаг удирдлагуудынхаа жанжин чиг шугамыг би үргэлжлүүлэх болно. Энэхүү жилийн тайланд ХасБанкны Хүндэт дарга ноён Чулууны Ганболд, Гүйцэтгэх захирал асан ноён Магваны Болдоо нарт талархал илэрхийлье. Манай байгууллагын ололт амжилтад тэд чухал үүрэг гүйцэтгэсэн манлайлагчид байсан төдийгүй 2011 онд ТСНэгдэлд орсон цагаас минь намайг дэмжиж удирдан чиглүүлж байв. Мөн шилжилтийн амаргүй үед Гүйцэтгэх удирдлагын багийг удирдан чиглүүлсэн ТСНэгдэл, ХасБанкны ТУЗ-ийн дарга ноён Санжай Гүптад талархал дэвшүүлмээр байна.

2009 онд Гүйцэтгэх захирлаар Болдоо захирал томилогдоход ТСНэгдэл хөгжлийнхөө хоёр дахь арван жилийн босго давж байсан түүхэн үе байсан. Миний гүйцэтгэх захирлаар ажилласан эхний жил буюу 2019 он мөн л ХасБанкны шинэ үеийн эхлэл буюу хөгжлийн гурав дахь арван жилийн эхлэл санаандгүй тохиолоо. Банкны салбар тогтвортой хөгжсөн хэвээр байгаа хэдий ч харилцагчийн зан төлөв үлэмж өөрчлөгдөн, технологийн хурдацтай дэвшил, банкны зохицуулалт улам чангарсан үе ирж байгаа нь үүрэгт ажлаа

авснаас хойш надад улам бүр тодорхой болсон.

Зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх гэсэн арилжааны банкууд болох гол тоглогчтой хязгаарлагдмал тоглоом хэдийн өөрчлөгдсөн. Одоо тоглоомын шинэ дүрмийг хөдөлгөөнт операторууд, хэрэглэгчийн сүлжээ, банк бус санхүүгийн байгууллага, финтекүүд, IPO болон шинээр гарч ирэх бусад тоглогчид бүгд шинэ журам, танигдаагүй хувьсагчуудыг авчирч банкны салбар дахь өрсөлдөөний дүр зургийг тодорхойлж байна. Бид цаашид зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх стратегийг дагаж мөрдөх бус, бүтээмжийг сайжруулах, хүн болон технологид хөрөнгө оруулах, зээлийн чанарыг сайжруулах, тогтвортой хөгжлийн бизнес загварыг дахин өөрчлөх нь бидний стратеги болж байна. Зах зээлд эзлэх хувь хэмжээ нь бидний зорилт бус, харин бидний хийж буй ажлын үр дүн болно.

Хувьцаа эзэмшигчид болон Захирлуудын зөвлөлөөс ирүүлсэн тулгамдсан зарим асуудлыг энэ захидлаар хөндье.

2019 оны ололт амжилт болон боломжууд, тулгарсан сорилт, хариу үйлдлүүдийг товч байдлаар нэгтгэж хүргэе. 2019 онд бидний дэвшүүлсэн стратегийн сонголтууд ойрын ирээдүйд ХасБанкийг улам хүчирхэг болгох юм.

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө:

2019 оны эцэст нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 11.9 хувь болж, мөн оны 3 дугаар сарынхтай харьцуулбал ойролцоогоор 300 пунктээр сайжирсан бөгөөд үүнд эрсдэлээр жигнэсэн активын эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтүүдийг харгалзсан болно. Удирдлагын багийн гол анхаарсан зүйл бол стратегийн чухал арга хэмжээнүүдийг авч банкны эрх зүйн шинэ зохицуулалтын шаардлагыг хангах явдал байлаа. Ингэснээр банкны хөрөнгө хангалттай сайжирна. Хөрөнгийн шинэ зохицуулалт хүчин

төгөлдөр болж үйлчилж эхлэхээс өмнө бид ирээдүйд илүү таатай нөхцөл байдлыг бий болгохын тулд хэд хэдэн хувилбартай хөрөнгийн уян хатан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн.

Зээлийн чанар: Иргэд, байгууллагын зээлийн багц, гадаад валютаар олгосон зээл, чанаргүй зээлийн удирдлага, зээлийн нэмэлт эрсдэлийн нөөц санд байршуулсан эрсдэлээр жигнэсэн актив (RWA) хөрөнгийн хэмжээг бууруулахад үлэмж хэмжээний цаг хугацаа зориулсан. Үүний зэрэгцээ эрсдэлийг удирдах бодлого журам, мөн зээл батлах эрх шилжүүлэх журмаа сайжруулсан. Бид зээлийн чанарыг сайжруулах, чанаргүй зээл, банкны эзэмшлийн худалдан борлуулах хөрөнгийн хэмжээг багасгахад давуу төвлөрч ажилласан хэвээр байна. 2020 онд эдгээр асуудалд хоёр дахин илүү хүч хандуулна.

Цэвэр хүүгийн орлогын маржин: Удирдлагын багаас өртөг өндөртэй гадаад валютын эх үүсвэрийг эргүүлэн төлөх, хамгаалаагүй гадаад валютын хэмжээг бууруулж нийт өрийн бүтцийг оновчтой болгож банкны актив пассивын удирдлагыг сайжруулсан. Актив пассивын удирдлагыг оновчтой болгох нь банкны ашигт ажиллагааг сайжруулах тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.

Үйл ажиллагааны зардал: Үйл ажиллагааны зардлын суурийг анхааралтай судалж зардал багасгахад чиглэсэн хэд хэдэн санаачилга гаргаж хэрэгжүүлснээр зардлыг хяналтдаа авсан. 2015 оноос хойшхи хугацаанд үйл ажиллагааны зардал өмнөх оныхтой харьцуулбал анх удаа 5 хувиар буурсан. Үүний үр дүнд өмнөх жилтэй харьцуулбал орлого зардлын харьцаа 83.9 хувиас 59.9 хувь болж буурсан. 2020 онд бид мэдээлэл технологи дахь хөрөнгөө оновчтой болгоход анхаарч ажиллана.

Татварын өмнөх цэвэр ашиг: Татвар, зээлийн алдагдлын зардлын өмнөх цэвэр ашиг 44.2 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь 2018 онд 13.5 тэрбум төгрөг, 2017 онд 18.3 тэрбум төгрөг байсантай харьцуулбал үлэмж хэмжээний ахиц юм. Гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжирсан нь ирээдүйн зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах боломжийг олгосон юм.

Нөөцийн сан: Ирээдүйн тодорхой бус байдлаас банкаа хамгаалахын тулд чанаргүй зээл, банкны эзэмшлийн худалдан борлуулах хөрөнгөд зориулж зээлийн алдагдлын сан байгуулах нь тодорхой. 2019 онд 30.1 тэрбум төгрөгийг зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулсан, үүнд, IFRC зээлийн алдагдлын сан, банкны эзэмшлийн худалдан борлуулах хөрөнгө (БЭХБХ)-ийн нөөц сан, БЭХБХ борлуулалтын алдагдлын сан, дахин үнэлгээ хийсний алдагдал болон бусад хөрөнгийн сан багтана.

Цэвэр ашиг: ХасБанк 8.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Цаашид бид зорилтот сегментийн тогтвортой өсөлтийг хангаж, эрсдэлийн зохистой удирдлага, зардлын бүтцийг сайжруулж, хөрөнгө илүү үр ашигтай ашигласнаар хөрөнгийн өгөөжийг сайжруулахаар төлөвлөж байна.

Хөрөнгийн эрх зүйн зохицуулалт: Хөрөнгө нэмэгдүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг тогтмол мэдээлж, тулгарч буй сорилтуудын талаар Монголбанктай үр бүтээлтэй хамтран ажиллаж байна. Монголбанкнаас нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 11.5 хувьд хүргэх зорилтыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулах шийдвэрлэсэн. Мөн 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс

12.5 хувьд хүргэх зорилтыг 6 сараар буюу 2021 оны долдугаар сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулав. Эрсдэлээр жигнэсэн активын үндсэн зорилтуудад өөрчлөлт ороогүй болно.

Технологи: Технологи хөгжүүлэх, тоон системд шилжиж шилжилтийн хувьд бид мобайл банкны шинэ платформ бий болгоход анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2020 онд банкны шинэ үндсэн системд шилжихээр бэлтгэж байна. Банкны хэмжээнд бид дижитал шилжилт хийж мэдээлэл технологийн архитектур, дэд бүтцийг улам сайжруулснаар харилцагчийн үйлчилгээгээ чанаржуулж “Mobile First” эрин үед харилцагчдад банкны үйлчилгээг илүү хурдан шуурхай хүргэх, хүргэлтийн сувгуудаа илүү оновчтой болгоно.

Хүмүүс: Банкны шинэ стратегийн зорилтуудыг биелүүлэх чин эрмэлзэлтэй, үлгэр дуурайл болох 1300 хамтран ажиллагсадтай хүчтэй багийг удирдах нь нэр хүндийн хэрэг юм. Бид ажиллагсадгүйгээрээ 2019 оны үр дүнд хүрэх боломжгүй байлаа. Мэргэжлийн өндөр үр чадвартай, шилжилтийн амаргүй үед биднийг дэмжиж ажилласан нийт ажиллагсдадаа гүн талархал илэрхийлмээр байна. Цаашид шийдвэр гаргахад ажиллагсдын оролцоог хангах, ажил мэргэжлийн хөгжүүлэлт, залгамж халааг төлөвлөх, ажиллагсдын нөхөн олговор олгох зэрэг хүний нөөцийн бодлого журмыг сайжруулахад илүү анхаарч ажиллана.

ХасЛизинг: 5.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, өөрийн хөрөнгийн өгөөж 22.7 хувийн үзүүлэлттэй бас нэгэн амжилттай жилийг үдлээ. Чанаргүй зээлийн эзлэх хувь 0.7 буюу зээлийн чанар сайн хэвээр, нөөц сангуудыг оруулаад эрсдэл хаах харьцаа 281 хувь, орлого зардлын харьцаа 26.3 хувь байв.

Тэнгэр Даатгал: Компанийн 2019 оны зорилтууд биелэгдээгүй. Цэвэр ашиг 0.65 тэрбум төгрөг, хөрөнгийн өгөөж 6.8 хувь байв. Зардлын болон хохирлын харьцаа тус тус 56.9 болон 59.3 хувь байв. Улмаар нийлмэл харьцаа 116.2 хувь байв. Бид ирээдүйгээ өөдрөгөөр харж байна. 2020 оныг компани шинэ удирдлагатай эхэлсэн. Ажлын эхний үр дүн маш эерэг байгаа.

Төгсгөлд нь, эрх зүй, эдийн засаг, үйл ажиллагааны байнгын сорилттой хүрээлэн буй орчинд биднийг тууштай дэмжсэн ТУЗ-ийн дарга, Төлөөлөн Удирдах Зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон харилцагч нартаа ТСНэгдэл, ХасБанкны удирдлагын багийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

ХасБанк, ТСНэгдлийн Гүйцэтгэх захирлаар ажилласан эхний жилийг эргэн харахад 2019 оны ахиц дэвшил цаашид бидэнд урам зориг өгч байна. Бид тодорхой стратегитэй ажиллаж шийдвэрлэх ёстой гол гол асуудлуудаа онилсон. Зохион байгуулалтын хувьд бид бүтцээ илүү хэвтээ болгож өөрчилсөн бөгөөд 2019 оны 5 дугаар сараас удирдлагын баг стратегийн зорилтуудаа хэрэгжүүлэхээр гар нийлж ажиллалаа. Нэр хүндтэй, брэнд, сайн имиджтэй, сайн засаглалтай, ил тод байдал, олон талын хувьцаа эзэмшигчидтэй гэсэн сайн өв уламжлалаа бид хадгалж авч үлдсэн бөгөөд хэтийн стратегийн сууриа болгон үргэлжлүүлнэ.

2020 онд бид стратегийн зорилтуудаа ягштал баримталж, удирдлагын баг хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд үргэлжлүүлэн анхаарч 2020 оны болон хэтийн зорилтоо биелүүлэх болно. Хүчтэй, хариуцлагатай банк болоход бид бүхий л хүч чадлаа дайчлан ажиллана.

Гүмэнжавын Цэвэгжав
ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн
Гүйцэтгэх захирал

2019 оны онцлох үйл явдлууд

1-р сар

ХасБанкнаас Төслийн санхүүжилт хийсэн 10 мега ваттын нарны цахилгаан станц Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд ашиглалтад орлоо. Тус станц нь жилд 171 сая литр ус хэмнэж, хүлэмжийн хийн ялгарлыг 12,270 тн-оор бууруулна.

3-р сар

ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Санжай Гүпта сонгогдлоо.

ХасБанк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн Гүйцэтгэх захирлаар Гүмэнжавын Цэвэгжав томилогдлоо.

5-р сар

Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас шалгаруулдаг ТОП-100 ААН-ээс ХасБанк 13-т эрэмбэлэгдлээ.

7-р сар

ОУСК болон Нидерландын Хөгжлийн Агентлаг зэрэг 5 санхүүгийн байгууллагаас ЖДБ эрхлэгчдийг дэмжих зорилгоор 65 сая ам.долларын санхүүжилт авлаа.


9-р сар

Хадгаламж барьцаалсан зээлийг интернэт банкны платформоор дамжуулан авах боломжтой болсноор нийт 156 мянган зээл олгож, салбарын ачааллыг буурууллаа.

11-р сар

АТМ-ийнхээ тоог 2 дахин нэмэгдүүлж, улсдаа 2-т орох өргөн сүлжээтэй боллоо.

Мөн 2017 оноос эхлэн АТМ-ээс авах бүх үйлчилгээ болон интернэт банкаар ХасБанкны данс хооронд хийх гүйлгээний шимтгэлүүдийг тэглэсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 1.1 тэрбум төгрөгийн шимтгэлийг харилцагчдадаа хэмнэж өгчээ.



2-р сар

Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран “Ногоон бэлчээр төсөл”-ийг Ховд аймгийн Чандмань суманд хэрэгжүүлэхээр боллоо.

4-р сар

Финтекүүдийг банкны үйл ажиллагаатай холбох eGateway төслийг хэрэгжүүлэн, NEG wallet, Thunes, Candy төлбөрийн картын захиалга, 360 Файнанс гэх мэт 8 байгууллагатай хамтран ажиллаж байна.

6-р сар

Candy төлбөрийн карт эзэмшигчид цуглуулсан Candy-гээ ХасБанкны АТМ-ээс бэлэн мөнгө болгон шимтгэлгүй авах боломжтой боллоо.

8-р сар

Харилцагчийн мэдээллийг шинэчлэн баталгаажуулах ажлыг орон даяар зохион байгуулж, 200 мянга орчим харилцагчийн мэдээллийг шинэчиллээ.

10-р сар

Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг банкны системд анх удаа ХасБанк авснаар финтек компаниудыг төлбөрийн системд оролцох томоохон гарцыг нээж өглөө.







Уур амьсгалын ногоон сан, БОАЖЯ-тай хамтран “Ногоон санхүүжилтийн чуулган”-ыг 3 дахь жилдээ зохион байгуулж, цахилгаан халаагуур, дулаалгын 8%-ийн хүүтэй зээлүүдийг олгож эхэллээ.

12-р сар

CANDY төлбөрийн картыг Мобикомын үйлчилгээний салбаруудад захиалах боломжтой боллоо.

Нидерландын Хөгжлийн Агентлагаас 100 сая ам.долларын хамтын санхүүжилтийн эх үүсвэр авах гэрээнд гарын үсэг зурлаа.

Санхүүгийн гүйцэтгэл



Макро эдийн засгийн орчин

Монгол Улсын эдийн засгийн ДНБ-ний хэмжээ 2019 онд 37 их наяд төгрөг буюу 5.1 нэгж хувиар өссөн нь 2017 оны 1-р улирлаас хойших хамгийн бага үзүүлэлт юм. Бүтцийн хувьд өрхийн хэрэглээ ДНБ-ний 55.2%, засгийн газрын хэрэглээ 12.1%, нийт хөрөнгө 35.8% бол цэвэр экспорт -3.15%-г тус тус эзэлж байна. Урьдчилсан байдлаар 2020-2021 оны хооронд дунджаар 5.6% гэсэн эерэг хүлээлттэй байсан боловч богино болон дунд хугацааны төлөв, БНХАУ-д гарсан Ковид-19 дэгдэлттэй холбоотойгоор эрс доройтож 3.0-4.5% хүртэл буурсан байдалтай байна.




Жилийн эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 2018 онтой харьцуулахад 0.4 нэгжээр өсөж 8.1% хүрсэн бол харин сарын дундаж цалин болох 1.2 сая төгрөг нь ерөнхийдөө өөрчлөгдөөгүй байна. Үүний зэрэгцээ, өрхийн бодит орлого 3-р улирлын байдлаар жилийн хугацаанд 8.6%-н өсөлттэй үзүүлэлттэй байв.

Дотоодын эдийн засгийн тодорхойгүй байдал нь БНХАУ болон АНУ-ын худалдааны гэрээ болон АНУ-аас бусад улсаас татах эрчим хүчний импорт зэргээс шалтгаалсан нөлөөлөлтэй байна. Түүнчлэн, Хятад болон Монголын эдийн засгийн нягт уялдаа холбоог харгалзан үзвэл Ковид-19 вирус дэгдсэний улмаас эдийн засгийн төлөв байдалд сөргөөр нөлөөлж байна. БНХАУ-ын хилийг вирус болон байгаль орчны цочир үйл явдал (ган гачиг/үер, зуд турхан г.м)-аас үүдэн сунжруулан хаах нь үүссэн тодорхойгүй байдалд нэрмээс болно.

Гадаад худалдааны хувьд Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос тасралтгүй өсөж, 2019 онд тэнцлийн илүүдэл 1.5 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 355.4 сая ам.доллар буюу 31.3%-аар өссөн дүн юм. 2019 оны байдлаар манай улсын экспортын 89.1%-ийг БНХАУ эзэлж байна. БНХАУ руу гаргасан нийт экспортын бараа бүтээгдэхүүний 44% нь нүүрс, 26.4% нь зэсийн баяжмал бүрдүүлж байна.

Оюу толгой ХХК-ний мэдээлснээр, 2019 онд зэсийн олборлолт 8%, алтны олборлолт 15.2%-аар хумигдсан төдийгүй хүдрийн агууламж бага байгаагаас үүдэн зэс, алтны олборлолтын бууралт 2020 онд мөн үргэлжлэх төлөвтэй байна гэж үзжээ. Үүнд 9-р сард засварын улмаас ОТ ХХК баяжуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг түр зогсоосон нь мөн нөлөөлсөн төдийгүй 2021 онд өндөр агууламжтай хүдэр, алтны олборлолт мэдэгдэхүйц нэмэгдэх хүлээлт байна.



Харилцах дансны алдагдал 2018 онд 2.2 тэрбум ам.доллар байсан бол 2019 онд 1.7 тэрбум ам.доллар болж буурсан үзүүлэлттэй гарсан. Экспортын өсөлтийн тогтвортой байдал (2019 онд 8.7%) болон импортын өсөлтийн цочмог бууралт (2018 оны 5-р сард 45.5% байснаас 2019 онд 4.3% хүртэл) нь энэхүү үзүүлэлтэд нөлөөлсөн. Жилийн туршид экспортын эрэлт сайн байсан нь түүхий эдийн үнэ (ялангуяа нүүрс, төмрийн хүдэр) харьцангуй өндөр түвшинд байхад нөлөөлсөн.

Төсвийн тэнцлийг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд, 2016 онд ДНБ 15.3%-ийн дутагдалтай байснаас 2018 онд 2.6%, 2019 онд 1.4%-ийн илүүдэлтэй гарсан байна. Засгийн газар 2019 онд аливаа төсвийн тодотгол хийхээс түдгэлзэж, зарлагыг хяналтандаа байлгаж байв.

УИХ 2020 оны өргөтгөсөн төсөв баталсан бөгөөд уг төсөвт татварын төвлөрөл сайжирч, гадаад худалдааны урсгал нэмэгдэхийн хэрээр засгийн газрын орлого 16.6 хувиар өснө гэж үзжээ.


Гэхдээ ойрын үед тулгамдаж буй нөхцөл байдлыг харгалзан үзвэл, энэхүү хүлээлтийн зарим нэг төсөөлөл буюу ялангуяа

БНХАУ руу экспортлох нүүрсны хэмжээг 2019 онтой харьцуулахад 14.7%-аар өснө гэсэн нь хэтэрхий өөдрөг гэж харагдаж байна.

Хэрэглээний үнийн индексийн инфляци сүүлийн саруудад огцом унасан нь махны үнийн бууралт, зээлийн өсөлтийн удаашралт мөн өмнөх жилийн суурь нөлөөлөл зэрэг нь инфляцийн түвшин буурах гол хүчин зүйл байв. Улирлын нөлөөтэй махны үнийн бууралт нь 9-р сард 19% байсан нь хүнсний бүтээгдэхүүний инфляцийг 2019 оны 12-р сард жилийн 8.3% хүртэл буурахад гол нөлөөг үзүүлсэн.

2019 онд, төгрөгийн ханш ам.доллартай харьцуулахад 3.4%, Хятадын юантай харьцуулахад 2.1% буурсан нь 2018 онтой харьцуулбал 9% болон 3.4% тус тус суларсан байна. 2019 онд Монголбанк төгрөгийн ханшийг барьж тогтоохын тулд 2.86 тэрбум ам.доллар зарсан нь 2018 оны 1.5 тэрбумээс өссөн үзүүлэлт юм.

Улсын валютын нөөц болон ам.долларын ханш
2014.06 сар - 2019.12 сар




Эх сурвалж: Монголбанк

Банкны салбар

Байгууллага болон иргэдийн зээлийн нийт үлдэгдэл 2019 онд өмнөх оны мөн үеэс 870.4 тэрбум төгрөгөөр буюу 5.1%-аар өссөн. Нийт 18.1 их наяд төгрөгийн багц байгаагаас 9.4 их наяд төгрөг буюу 52.1% нь иргэдийн зээл харин 8.7 их наяд төгрөг буюу 47.9% нь байгууллагын зээл эзэлж байна.

Системийн хувьд энэхүү 5.1%-ийн өсөлт нь 2018 оны үзүүлэлт болох 25.8%-аас эрс буурсан байгаа бөгөөд энэ нь Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа макро-эдийн засгийн хатуу бодлогууд буюу өр, орлогын харьцааг 100%-аас 60% болтол бууруулсан, ипотекийн бус өрхийн зээлийн хугацааг бууруулсан мөн ханшийн хамгаалалтгүй гадаад эх үүсвэрийн эрсдэлийн үнэлгээг өсгөсөн зэргээс үүдэлтэй үр дүн юм.


Банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ 2019 оны 12-р сард нийт зээлийн 10.1 хувийг эзэлж буй нь өмнөх жилийн мөн үеэс 0.3 нэгж хувиар буурчээ. Чанаргүй зээлийн хэмжээ тогтмол нэмэгдэж байгаа нь банкны салбарын чанарын тогтвортой байдалд анхаарал хандуулах зайлшгүй шаардлагыг харуулж байна.



Монголбанкны мэдээлснээр системийн хэмжээний өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт нь хамгийн доод шалгуур үзүүлэлт болох 12%-аас давсан үзүүлэлттэй гарчээ. Нийт банкны нөөцийн хуримтлал 2019 оны 12-р сарын байдлаар нийт хадгаламжийн 27 орчим хувийг эзэлж буй нь зайлшгүй байх нөөцийн доод хэмжээ болох 10.5%-аас давсан үзүүлэлт юм. Түүнчлэн, хөрвөх чадварын харьцаа буюу банкны нөөц, төв банкны үнэт цаас, Засгийн газрын бонд зэргийг багтаасан түргэн хөрвөх активуудын банкны нийт өртэй харьцуулсан харьцаа нь 2019 оны 12-р сард 37.2% буюу МБ-с тогтоосон доод хэмжээ болох 25%-аас мөн давсан үзүүлэлт болно.

Өмнөх жилтэй харьцуулбал, 2019 оны 11-р сарын эцсийн байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.0% буюу 1.2 нэгж хувиар буурч, гадаад валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 10.7% буюу 1.9 нэгж хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламжийн хүү 2017 оны туршид дунджаар 13% орчим байсан бол 2018 онд 12% харин 2019 онд 10.5% болж буурсан байна. Хадгаламжийн хүү харьцангуй багаар буурч байгаа нь банкуудын хооронд цөөн хэдэн томоохон хадгаламж эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжид хүчтэй өрсөлдөөн байгааг харуулж байна.

Сарын эцсийн байдлаар зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр), дотоод валютын зээлийн жигнэсэн дундаж хүү, (хувь)



Монголбанк болон Дэлхийн банкнаас сүүлд хийсэн судалгаагаар түүхий эдийн үнэ, эдийн засгийн өсөлт нь хувь хүний зээлийн өсөлтөд хамгийн хүчтэй нөлөөлдөг хүчин зүйл болох нь тогтоогджээ.

Тиймээс зээлийн өсөлт нь макро эдийн засгийн цочролтой нягт холбоотой юм. Ковид-19 мөн бараа бүтээгдэхүүний үнийн уналт зэрэг гадны цохилтуудын сөрөг нөлөөллийг бууруулахын тулд эрх баригчид бодлогын хүүг 100 суурь нэгжээр 10% болгон бууруулж 2020 оны 3-р сард мөнгөний бодлогыг сулруулахаар шийдвэрлэлээ. Үүнийг дагасан төсвийн нөлөөллийн арга хэмжээ гарч болзошгүй юм. Гэсэн хэдий ч ойрын үеийн эдийн засгийн бууралтаас харахад 2020 онд зээлийн тэлэлтийн мөчлөг бий болох нь боломжгүй мэт харагдаж байна.

Стратегийн шинэчлэл

“Mobile First” эрин үед харилцагчдад банкны үйлчилгээг илүү хурдан шуурхай хүргэх, хүргэлтийн сувгуудаа илүү оновчтой болгоно.

Гүйцэтгэх удирдлага

(2019 оны 12-р сарын 31-ний байдлаар)

Гүмэнжавын Цэвэгжав

Гүйцэтгэх захирал
2019.05.08-нд томилогдсон

Энэбишийн Уламбаяр

Үйл ажиллагаа хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Ганзоригийн Зул

Хүний нөөц хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Энхбаярын Ундармаа

Ерөнхий аудитор
2016.05.05-нд томилогдсон

Ганзоригийн Эрдэнэбаяр

Санхүү хариуцсан захирал
2013.01.07-нд томилогдсон

Илия Аврамов

Эрсдэл хариуцсан захирал
2019.10.15-нд томилогдсон

Хүрэлбаатарын Өнөрбат

Мэдээллийн технологи хариуцсан захирал (Үүрэг гүйцэтгэгч) 2019.01.02-нд томилогдсон

Дашнямын Ашидмаа

Хөрөнгө оруулагчдын харилцаа, компанийн засаглал хариуцсан захирал
2014.08.01-нд томилогдсон

Төлөөлөн Удирдах Зөвлөл

(2019 оны 12-р сарын 31-ний байдлаар)

ТУЗ-ийн дарга

Санжай Гүпта

2019.03.28-нд сонгогдсон

ТУЗ-ийн гишүүд

Анджей Витак

2019.03.28-нд сонгогдсон

Майкл Мадден

2019.03.28-нд дахин сонгогдсон

Нямтайширын Цэлмүүн

2019.03.28-нд дахин сонгогдсон

Гүмэнжавын Цэвэгжав²

2019.05.08-нд Гүйцэтгэх захирлаар томилогдсон

Нираж Вэдва

2019.03.28-нд хараат бус гишүүнээр сонгогдсон

Мелисса Мой Тиан¹

2019.06.19-нд сонгогдсон

Риожи Нишимура

2018.03.29-нд дахин сонгогдсон

Ив Жако

2018.03.29-нд дахин сонгогдсон

Баянсаны Уламбаяр

2019.03.28-нд хараат бус гишүүнээр дахин сонгогдсон

Морис Лам³

2019.03.27-нд хараат бус гишүүнээр сонгогдсон

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

ХасБанк нь ТэнГэр Санхүүгийн Нэгдэл /ТСН/ ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани юм.

ТСН ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй ба одоогоор Монгол Улсын банк, санхүүгийн салбарт ийм олон талын хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй цорын ганц компани юм.

20.00%	МОНГОЛЫН АЛТ /МАК/	
17.17 %	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ	
16.81 %	ОРИКС КОРПОРАЦИ	
12.91 %	ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНК	
10.52 %	КАНАДЫН ҮНДЭСНИЙ БАНК	
10.15 %	РОНОК ПАРТНЕРЗ	
6.63 %	МОНГОЛИАН ФАЙНЭНШЛ СЕРВИСИЗ	
3.73 %	ТРИОДОС ФЭЙР ШЭЙР ФАНД	
1.59 %	НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ ТББ	
0.30 %	УЛААНБААТАР РОТАРИ КЛУБ ТББ	
0.10 %	МАГВАНЫ БОЛДОО	
0.09 %	ЧУЛУУНЫ ГАНБОЛД	

¹2020 онд болох Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдана.

²2020 онд болох Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдана.

³2020 онд болох Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн батлагдана.

Иргэдийн Банк



355 ATM +152%



5000 POS +70%



Нийт зээлийн **60%** нь цахимаар олгогдсон.

ДИЖИТАЛ БАНК

2018-2019 он ХасБанк цахим шилжилтийг эхлүүлж, банкны үндсэн систем, системийн дэд бүтцээ сайжруулж эхэлсэн онцгой үе байлаа. Эдгээр сайжруулалт нь цахим шилжилтийг хийх үндэс суурь болоод зогсохгүй цаашлаад шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай нэвтрүүлж, харилцагч банкны үйлчилгээг саадгүй авахад чиглэж буй юм.

ХасБанк нь стратегийн түншлэлийнхээ хүрээнд 360 Финанс, НЭГ, HiPay, Кэнди цахим мөнгө, Thunes зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн харилцагчдынхаа хэрэгцээ, хүсэл шаардлагад нийцсэн, хүртээмжтэй, өдөр тутмын банкны үйлчилгээг энгийн бөгөөд хялбар хүртэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Бид стратегийн түншүүддээ дэвшилтэт технологи болох нээлттэй API-г санал болгосноор гуравдагч байгууллага болох Финтек компаниудад банкны үндсэн системтэй холбогдон харилцагчдад төлбөрийн шинэ үйлчилгээ, бизнесийн шинэ боломжуудыг өргөн хүрээнд хүргэх боломжийг нээн өгч байгаа юм.

Thunes нь дээрх зарчимаар ХасБанктай холбогдсоноор гадаадаас Монгол Улсын аль ч банкны данс руу маш хурднаар, хамгийн бага шимтгэлтэйгээр мөнгө шилжүүлэх боломжтой болсон.

2018 оноос хойш ХасБанк цахим сувгуудынхаа хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлснээр ATM 152%-р, ПОС терминал 70%-р өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр өсөлтийн үр дүнд харилцагчид орон даяар байх ХасБанкны ATM-р ямар ч шимтгэлгүй үйлчлүүлэхийн зэрэгцээ ХасБанкны картаар үйлчлэгч байгууллагуудаар үйлчлүүлэн тодорхой урамшуулал, хөнгөлөлтийг авч байна.

ХасБанк нь 360 Финанс байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд банкуудаас тавьдаг зарим шаардлагыг хангах боломжгүй бичил бизнес эрхлэгч нарын бэлэн бус төлбөр тооцоог нь шийдэх зорилгоор мобайл ПОС терминалыг нэвтрүүлсэн нь амжилттай хэрэгжиж орон даяар 4500 гаруй ашиглагдаж байна.

Түүнчлэн, үүрэн холбооны тэргүүлэгч Мобиком корпорацийн хамтран Кэнди брэндийн төлбөрийн картыг зах зээлд нэвтрүүлээ. Кэнди нь Мобиком корпорацийн лоялти урамшууллын хөтөлбөр байсан бол улмаар Монголбанкнаас цахим мөнгөний эрхээ авсан МУ-ын цорын ганц цахим мөнгө болсон. Кэнди карт нь карт эзэмшигчдэдээ худалдан авалт бүрийн 1%-ийг буцаан олгодог бөгөөд харилцагч Кэнди и-түрүүвч аппликэйшнээр дамжуулан бусад бүтээгдэхүүн үйлчилгээг саадгүй авах боломжтой. 1 Кэнди цахим мөнгө нь 1 төгрөгтэй тэнцүү ханштай учир кэнди карт эзэмшигчид нь цуглуулсан кэнди цахим мөнгөө ХасБанкны ATM-с бэлэн мөнгө болгон авах, ХасБанкны ПОС терминал дээр Кэнди цахим мөнгөөрөө бараа үйлчилгээний төлбөрөө төлөх боломжтой юм.

Хамтын ажиллагааны хүрээнд харилцагчид банкны салбараас төдийгүй Мобикомын үйлчилгээний салбарт очиж Кэнди төлбөрийн картыг захиалах боломжтой болсон.

ХасБанк нь харилцагчдад интернэт банкаараа дамжуулан банкны салбарт заавал биеэр ирэхгүйгээр, хадгаламжаа барьцаалсан зээлийг 8 секундийн дотор авах боломжийг бүрдүүлж өгсөн нь харилцагчдын талархлыг ихээр хүлээж байна. Өнгөрсөн оны 4-р улирлын байдлаар хадгаламж барьцаалсан зээлийн 77% нь зайнаас буюу цахимаар олгогдсон байна.

2019 онд ХасБанк нь банкны системийн хэмжээнд анх удаа Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, "Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам"-ыг үндэслэн Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг авлаа. ХасБанк Төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх энэхүү зөвшөөрлийг авснаар финтек компаниудыг төлбөрийн системд оролцох томоохон гарцыг нээн өгч байгаа юм. Үүний нэг жишээ нь төлбөр тооцооны HiPay компани өөрийн харилцагч нартаа онлайн төлбөрийн үйлчилгээг санал болгож эхэлсэн.



Харилцагч Б.Алтансүх нь 2012 онд ХасБанкнаас бичил бизнесийн зээл аван бизнесийн гараагаа эхлүүлж байжээ. Тэрээр эхнэр А.Оюунцэцэгтэйгээ хамтран гар утасны худалдаа, засварын газар ажиллуулдаг бөгөөд одоо хүртэл ХасБанкны үнэнч харилцагч юм. Драгон төвийн автобусны буудлын дэргэд үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүний бизнес жил ирэх тусам өргөжин тэлсээр өнөөдрийн байдлаар 5 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тэрээр төлбөр тооцоогоо ихэвчлэн бэлэн мөнгөөр хийдэг байсан бол 2019 оноос эхлэн ХасБанкны ПОС төхөөрөмж авснаар бэлэн бусаар гүйцэтгэдэг болсон.

Ийнхүү цахим хэлбэрт шилжсэнээр борлуулалтын байдал, өсөлтөө хянахад хялбар болжээ. Б.Алтансүх "Бидэнд үргэлж бизнесийн эрч хүч, урам зориг өгдөг ХасБанк бидний хамгийн найдвартай санхүүгийн түнш болсон." хэмээн итгэл төгс хэлж байна.

Б. Алтансүх

Өнөр Тооцооны төвийн харилцагч

Иргэдийн Банк



Ирэх жилүүдэд ХасБанк цахим шилжилтийг хийхэд үргэлжлүүлэн анхаарч, Монголын банкны салбарт технологийн дэвшлийн давуу талуудыг нутагшуулахыг гол зорилгоо болгон ажиллаж, харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад үндэслэн өдөр тутмын банкны үйлчилгээг авахад ямар нэгэн хүндрэлгүй, хялбар байх үүднээс шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн ажиллах болно.



А. Зоригтсайхан

Нарантуул Тооцооны төвийн
Бичил зээлдэгч

Хэнтий аймгийн Зүүнхараа сумын уугуул Зоригтсайхан 2004 онд Улаанбаатар хотод шилжин ирж, Алтанжолоо Группт жолоочоор орсноор түүний түүх эхэлжээ. 2012 онд тэрээр өөрийн жижиг тээврийн үйлчилгээний бизнес эхлүүлэхээр зориг шулуудан ХасБанкны бичил бизнесийн зээлээр Hyundai Porter автомашин худалдан авчээ. Түүний бизнес маш амжилттай байсан тул хүрээгээ тэлэхээр нэмэлт зээл аван Амгалан захд нарийн боовны дэлгүүр нээсэн байна. Мөн хотод орж ирсэн цагаасаа л эхлэн мөрөөдсөн их гарын Jeer машинаа ч тэр 2019 онд худалдаж авч чадсан юм.

Энэ бүх амжилтаа тэрээр ХасБанктай холбон тайлбайрладаг. Зоригтсайхан бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаа, төлбөр тооцоондоо ХасБанкны ПОС төхөөрөмжийг ашиглахын зэрэгцээ гар утсаараа дамжуулан хадгаламж барьцаалсан зээл авч гэнэтийн мөнгөний хэрэгцээгээ шийддэг.

ИРГЭДИЙН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

Иргэдээс татсан, харилцах, хадгаламжийн багц өмнөх оноос 13 хувиар өсч 1 их наяд 667 тэрбум төгрөгт, нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 822 мянгад хүрсний 198 мянган хадгаламж эзэмшигч нь хүүхэд байна. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банк хадгаламжийн хүүг шат дараалан бууруулсан нь тайлант хугацаанд эх үүсвэрийн өртөг 1 нэгж хувиар буурч, банкны санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд голлон нөлөөллөө.

2019 онд Монголбанкнаас хэрэгжүүлсэн төлбөрийн системийн шинэчлэл автомат клиринг хаус (ACH) төслийг амжилттай хэрэгжүүлж, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх зөвшөөрлийг банкны системийн хувьд анх удаа авлаа. Ингэснээр финтек компаниуд төлбөр тооцоог гүйцэтгэхээс гадна биллер байгууллагуудын төлбөр цуглуулах үйлчилгээгээр дамжуулан харилцах дансны багцын өсөлт нэмэгдүүлэх боломж бүрдлээ.

ИРГЭДИЙН ЗЭЭЛ

Тайлант хугацаанд Монголбанкнаас хэрэглээний зээлийн нөхцөл чангаруулж зээлийн олголт таных бодлого баримталсан боловч ХасБанк иргэдийн зээлийн багцыг тогтвортой түвшинд хадгалж 1 их наяд 302 тэрбум төгрөгт хүргэж, харилцагчийн тоог 12 мянгаар нэмэгдүүлж чадлаа. Мөн харилцагчийг хамгаалах зарчмуудыг зээлийн үйл ажиллагаандаа мөрдөж, банкны харилцагчдыг өрийн дарамтад оруулах бус хэрэгцээтэй санхүүжилтийг олгосноор иргэдийн чанаргүй зээлийн түвшинг 4.2 хувьд барьж банкны салбарт тэргүүлэх үр дүнг үзүүлээ.

Харилцагчдад зээлийн бүтээгдэхүүнийг түргэн шуурхай, чирэгдэлгүйгээр хүргэх дэвшилтэт технологийг ашиглан цахим зээлийн бүтээгдэхүүнүүд (Онлайн хадгаламж барьцаалсан зээл, ПОС 360 зээл) нэвтрүүлснээр 2019 оны нийт зээл олголтын 60 хүртэл хувь нь цахимаар олгогдлоо.



Бадамлянхуа эмнэлэг

Увс салбарын харилцагч

Увс аймгийн Улаангом сумын 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Бадамлянхуа эмнэлэг нь 2010 оны 6-р сарын 1-нд байгуулагдаж Увс аймгийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Тэрээр баруун 5 аймгийн олон мянган үйлчлүүлэгчдээ ХасБанкныхаа талаар үргэлж өөрийн сэтгэгдлээ хуваалцдаг бөгөөд “Амьдралд ашид хамтдаа” гэх уриагаар биднийг угтан авдаг билээ.

Тус эмнэлэг нь эмэгтэйчүүдийн хавдрын үзлэг, оношилгоо, эмчилгээ болон үргүйдлийн чиглэлээр ажиллаж 2013 он хүртэл 2D ЭХО аппаратыг ашиглаж байсан ба онош тодруулах зорилгоор 3 дахь шатлалын эмнэлэг рүү эхчүүд, эмэгтэйчүүдийг илгээж байсан.

Эрүүл мэндийн 2010-2013 оны статистик үзүүлэлтүүдээс харахад эмэгтэйчүүдийн хавдар хожуу шатандаа оношлогдож, ургийн гаж хөгжил нэмэгдсэн зэрэг үзүүлэлтүүд анхаарал татсан ба ЭХО оношилгооны чанар шаардлага хангахгүй байгаад үндэслэн 2013 оноос Жайка Олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгийг хүссэн төсөл бичиж дэмжлэг авч танай банктai хамтран ажилласан билээ.

Тус төслөөр 2013 онд Солонгосын Медисон – Самсунг компаний үйлдвэрлэсэн ACCUVIX A30 маркийн 4D өнгөт доплертой ЭХО аппаратыг оношилгооны зорилгоор худалдан авч эмчийг Солонгост сургаж чадавхижуулан Увс нутгийн эхчүүд, эмэгтэйчүүдийн өндгөвчний болон умайн хүзүүний хавдар, ургийн гажиг илрүүлэх оношлогоог өндөр түвшинд хийдэг болсноор үйлчилгээний чирэгдэл буурч, улмаар Ховд, Баян-Өлгий, Завхан аймгийн хил залгаа сумдын 210 гаруй иргэд манай эмнэлгээр үйлчлүүлсэн байна.

Төсөлд хамрагдсанаар 50265 хүнд үйлчилж өндгөвчний хавдар -65 тохиолдол, умайн хүзүүний хорт хавдар -229 тохиолдол, Умайн хүзүүний хавдрын урьдал өвчин- 1552 тохиолдлыг тус тус оношлон хяналтдаа авч, эрүүлжүүлэх арга хэмжээг аваад байна.

Ийнхүү алслагдсан нутгийн иргэдэд хүргэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, чирэгдлийг бууруулан харьцангуй хямд үнээр иргэдэд үйлчилж, эдийн засгийн хэмнэлтийг иргэдэд олгож байгаа нь тус төслийн зээлийн бодит үр дүн хэмээн үзэж, талархаж байна.



Харилцагчаа хамгаалах зарчмууд

Бид дэлхий дахинд дэмжигдсэн Харилцагчаа хамгаалах зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Францад төвтэй, бичил санхүү, нийгмийн хариуцлагын рейтинг тогтоодог, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Planet Rating агентлаг 2015 онд ХасБанканд үнэлгээ хийж, 2017 онд манай ТУЗ Харилцагчдыг хамгаалах зарчмуудыг баримталж ажиллахаа албан ёсоор дахин нотолж, Харилцагчдыг хамгаалах зарчмуудын бодлогоо шинэчлэн гаргасан юм.

- 1

Бүтээгдэхүүний зохих ёсны дизайн, хүргэлт
Бид бүтээгдэхүүн, түүнийг хүргэх сувгийн дизайныг харилцагчдад хохирол учруулахгүйгээр гаргахад зохих анхаарал тавина. Бүтээгдэхүүн, хүргэлтийн сувгийн дизайн гаргахдаа харилцагчдын онцлогийг тусгана.
- 2

Хэт их өр зээлтэй болохоос сэргийлнэ
Бид зээл олгох ажлын бүхий л үе шатанд харилцагч хэт их өрөнд оролгүйгээр зээлээ төлөх чадвартай эсэхийг тодруулахад зохих анхаарал тавьж ажиллана. Бид хэт их өр зээлтэй болохоос сэргийлэх дотоод систем нэвтрүүлэн, мониторинг хийж, зах зээлийн түвшний зээлийн эрсдэлийн удирдлагаа сайжруулах хүчин чармайлтыг дэмжиж ажиллана.
- 3

Ил тод байдал
Бид тодорхой, хангалттай, цаг үеийн мэдээллийг мэдлэгтэй шийдвэр гаргах хэмжээнд ойлгож чадах хэлбэр, хэлээр харилцагчдад хүргэхийг чармайж ажиллана. Бүтээгдэхүүний үнэ өртөг, нэр томъёо, нөхцөл болзлын тухай ил тод мэдээллийн хэрэгцээнд илүү анхаарал тавина.
- 4

Үнийг хариуцлагатай тогтооно
Үнэ тогтоох, нэр томъёо, нөхцөл гаргахдаа Банкны тогтвортой ажиллагааг хангахын зэрэгцээ харилцагчдад боломжийн хэмжээнд байлгахад анхаарна. Байгууллагын удирдлага хадгаламжийн бодит өгөөжийг ашигтай байлгахын төлөө ажиллана.
- 5

Үйлчлүүлэгчдэд шударга, хүндэтгэлтэй хандана
Бид харилцагчидтайгаа шударга, хүндэтгэлтэй харьцахыг чармайн ажиллах болно. Бид ялгаварлан гадуурхахгүй. Байгууллагын удирдлага авилгалын үйлдэл, мөн ажилтнууд болон агентуудын түрэмгий, зүй бус харьцаа, ялангуяа зээл борлуулах, өр барагдуулах ажиллагааны үеэрх тийм байдлыг илрүүлэх, засаж залруулах зохих ёсны арга хэмжээ авч ажиллана.
- 6

Харилцагчийн мэдээллийн нууцлалт
Хувь харилцагчийн дата мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжийн хүрээнд хүндэтгэн ажиллана. Дата мэдээллийг зөвхөн холбогдох мэдээлэл бүртгэж авах явцад, эсвэл хуульд өөрөөр заагаагүй бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ашиглана.
- 7

Санал гомдол барагдуулах механизм
Байгууллагын удирдлага харилцагчдын санал гомдлыг хүлээн авч, асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх хариуцлагатай механизм ажиллуулж, асуудал тус бүрийг шийдвэрлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулахад ашиглана.

Салбарын удирдлага

Цахим банкны үйлчилгээ хөгжихийн хэрээр төлбөр тооцоо болон зарим зээлийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж биет салбарын ачаалал буурах хандлагатай байна. Хэдий тийм боловч харилцагчид банктай харилцаа холбоо тогтоохын тулд банкны салбар дээр очиж, банкны ажилтнуудаас санхүүгийн зөвлөгөө авах сонирхол хэвээр байна.

Үүнтэй уялдуулан харилцагчид тав тухтай үйлчилгээ үзүүлэх зорилгоор салбаруудад хөрөнгө оруулалт хийхээс гадна харилцагчид санхүүгийн зөвлөгөө өгдөг ажилтнуудыг шинээр авах, сургах ажлыг зохион байгууллаа.

Салбаруудын үр ашигтай ажиллагаа болон харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор зарим салбарыг нэгтгэх, байршлыг өөрчлөх ажлыг зохион байгууллаа. 2018 онд салбар, нэгжийн тоо 88 байсан бол 2019 оны эцсийн байдлаар 77 болж буурсан байна.

УЛААНБААТАР ХОТ	
САЛБАР	10
ТООЦООНЫ ТӨВ	24
ӨРГӨТГӨЛ	1
ОРОН НУТАГ	
САЛБАР	23
ТООЦООНЫ ТӨВ	17
ӨРГӨТГӨЛ	2
НИЙТ	77

Шагнал

Монгол Улсын шилдэг банк
Банкир сэтгүүл

ТОП 100 ААН
МУ-ын Засгийн газар,
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Банкны салбарын 2019 оны онцлох Энтрепренер
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Бизнес Банк

Бизнес банк нь эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагчдадаа өөрсдийн өндөр ур чадвар бүхий Харилцааны менежер, Зээлийн шинжээч нараараа дамжуулан банк санхүүгийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Бидний хувьд 2018 онд 39 хувийн өндөр өсөлттэй ажилласан бөгөөд 2019 онд тухайн багцын тогтвортой өсөлт, багцын оновчтой удирдлагад анхаарч ажиллалаа. Бидний 2019 онд баримтлан ажилласан стратегиас дурдвал:

Зээл олголт
215 тэрбум

Худалдааны санхүүжилт
4,792

ХАРИЛЦАГЧ ТӨВТЭЙ БАЙДАЛ:

- Банкны олон төрлийн санхүүгийн хэрэгслийг ашиглан санхүүгийн эрэлт хэрэгцээгээ үр ашигтай удирдах боломжийг бид харилцагчдадаа олгодог. Бэлэн мөнгөний удирдлагыг оновчтой хэрэгжүүлэхэд нь үзүүлдэг Мастер дансны үйлчилгээ нь үүний нэг тод жишээ юм.
- Бид харилцагч нартаа богино хугацааны ашгаас илүүтэйгээр урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгоход нь анхаарч дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
- Харилцагчийг хамгаалах бодлогын хүрээнд бид 65.2 тэрбум төгрөгтэй тэнцэх гадаад эх үүсвэрийн зээлийг төгрөгт хөрвүүлж харилцагчийг болзошгүй ханшийн эрсдэлээс сэргийллээ.
- Манай өндөр ур чадвартай харилцааны менежерүүд харилцагч нарынхаа бизнесийн онцлогийг мэдэрч тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн tailor-made үйлчилгээг үзүүлж байна.

БАГЦЫН ОНОВЧЛОЛ:

- Бизнес банкны 2019 оны гол зорилтуудын нэг нь огтлолцоо худалдааг нэмэгдүүлж багцаас хүртэх үр ашгийг сайжруулж багцын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх байлаа.
- Харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн tailor-made үйлчилгээг банкны төдийгүй Тэнгэр санхүүгийн нэгдэлийн бүтээгдэхүүнээр дамжуулан огтлолцоо худалдаагаар борлууллаа.
- Эдийн засгийн таагүй нөхцөл байдалд үүсэх эрсдэлээс харилцагчдаа урьдчилан сэргийлэх үүднээс эрсдэлийн тодорхой арга хэмжээнүүд авч ажилласны үр дүнд зээлийн нийт багцыг 15 хувиар бууруулсан бөгөөд 2019 онд нийт 215 тэрбум төгрөгийн зээлийн олголт хийсэн нь 2018 оны үзүүлэлтийн тал хувьтай тэнцэж байна.
- Гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүнээр 3.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг олж нийт 4,792 баталгаа, аккредитивыг нээж ажилласан байна.
- Шинэ хэлцлийн үр өгөөжийг тооцох санхүүгийн шинэ хэрэгслүүдийг зээлийн үйл ажиллагааны процесст нэвтрүүлэв.
- Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж 43 тэрбум төгрөгийн хамтын санхүүжилтийн хэлцлийг амжилттай хийлээ.



Ази фарм ХХК

Ази фарм ХХК нь бизнесийн амжилтаараа түүчээлж буй ХасБанкны харилцагчдын нэг юм. ХасБанк нь 2017 оноос эхлэн банкны бүхий л төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр Ази фарм ХХК-тай хамтарч ажиллаж эхэлсэн бөгөөд харилцагч томоохон эмийн сан, бөөний төвүүдэд анх удаагаа closed-loop кредит картыг амжилттай туршиж зах зээлд нэвтрүүлээ.

Энэ хугацаанд тус харилцагч нь салбар эмийн сангийн тоог 13-аар нэмэгдүүлж нийт салбарын тоог 34-д, эм ханган нийлүүлэх төвийн тоог 13-т хүргэж, шинээр 130 гаруй ажлын байрыг шинээр бий болгож нийт ажиллагсдын тоо 415-т хүрчээ.

Дэлхийн эмийн үйлдвэрлэлээр тэргүүлэгч Европын холбоо, АНУ, БНСУ, ОХУ, БНЭУ зэрэг 30 гаруй улсын 84 пүүс, компаниудтай хамтран ажиллаж, өндөр технологиор бэлтгэгдсэн, сайн чанарын 1800 гаруй нэр төрлийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг импортлохоос гадна эх орны бусад компаниудтай хамтран ажиллаж 6000 гаруй нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслүүдийг нийлүүлж үйл ажиллагаагаа жилээс жилд өргөжүүлэн тэлсээр ирлээ.

Эко Банк

ХасБанк нь Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн тэргүүлэгч санхүүгийн байгууллагын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн санхүүжилт олгон ажиллана.

Ногоон санхүүжилтийн санаачилга

ХасБанкны Эко банкны хэлтэс нь тогтвортой санхүүжилт хийх, бизнесийн үйл ажиллагааны эрчим хүчний хэмнэлтийг тооцох, хүлэмжийн хийн ялгарлын суурь үзүүлэлтийг тогтоох чиглэлээр мэргэшин ажиллаж буй Монгол Улсын банкны систем дэх цорын ганц банкны нэгж юм. Эко банкны хэлтэс нь 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Карбоны санхүүжилт, Тогтвортой эрчим хүчний санхүүжилт хийх гэсэн үндсэн гурван чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

НОГООН САНХҮҮЖИЛТ



Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

ХасБанкны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Ногоон зээлийн хөтөлбөрүүдийн үр нөлөөг өргөжүүлэх, өмнөх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах зорилгоор чадавх бэхжүүлэх, зээлийн хөтөлбөрийг олон нийтэд таниулан сурталчлахад чиглэсэн байдаг.

2019 онд ХасБанкны Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнес зээлийн хөтөлбөрийн гурав дахь жил тохиож байна. Хөтөлбөрийн хүрээнд ХасБанкны харилцагч жижиг дунд бизнес эрхлэгч нарт зориулан санхүүгийн болон эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр чадавхи бэхжүүлэх сургалтууд, зээлийн мэргэжилтнүүдэд зориулан ногоон зээлийг тодорхойлох талаар сургалтууд, мөн ногоон зээлийг тодорхойлох ажлыг хялбарчлах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй технологийн жагсаалт боловсруулах, Бизнес эрхлэгч нарт зориулан жил бүр Ногоон санхүүжилтийн форумыг уламжлал болгон зохион байгуулах зэрэг ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Мөн 2019 онд Уур амьсгалын Ногоон сантай хамтран Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр (EECLP) -ийг хэрэгжүүлж эхлээд байна. Уг зээлийн хөтөлбөрийн хүрээнд халаалтын шийдэл, байшингийн дулаалгад зориулан Хэрэглээний зээл олгох; халаагуурын зээлд хамрагдсан иргэдийн хуучин зуухыг хураан авч устгалд оруулах ажлыг зохион байгуулах; гэр хорооллын айл өрхөд халаалтын цэвэр технологийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс эрчим хүчний хэмнэлтийн ашиг тус, ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэл хуваалцах семинар зохион байгуулах; мөн зээлийн мэргэжилтнүүдэд зориулан эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн олголтын явц, өрхийн түвшинд эрчим хүчний хэмнэлтийн ашиг тусын талаарх сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

Түүнчлэн, бид Ногоон санхүүжилтийн гуравдугаар чуулганыг "Эко дулааны шийдлийг бид дэмжинэ" уриатайгаар зохион байгууллаа. Энэхүү чуулганд эрчим хүчний хэмнэлтийн чиглэлд ажиллаж буй оролцогч талуудын төлөөлөл болсон 250 оролцогч, тэр дундаа цэвэр халаалтын шийдэл, дулаалгын материал нийлүүлэгч жижиг дунд бизнес эрхлэгчдийг оролцуулсан болно. Энэ жилийн чуулганы онцлох үйл явдал нь гэр хорооллын айл өрхүүдэд халаагуур, дулаалгын

шийдлүүдийн талаар мэдээлэл өгөх зорилгоор нийлүүлэгч 30 байгууллагыг оролцуулан "Ногоон технологи-Ногоон зээл" үзэсгэлэнг хоёр өдрийн турш ажиллуулсан явдал байлаа.

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хийгдсэн онцлох ажлууд

- 2010-2015: Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гэр хорооллын өрхийн 80 орчим хувьд ХасБанкны бүтээгдэхүүн борлуулалтын цэгээр дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг татаастай үнээр борлуулсан.
- 2017-2019: Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд чадавх бэхжүүлэх, хөтөлбөрийг олон нийтэд таниулах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулав. 2019 онд 384 харилцагч, 285 зээлийн мэргэжилтнийг эрчим хүчний хэмнэлтийн талаарх сургалт, семинарт хамруулаад байна.
- 2018: ХасБанк нь Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагын чадавхи бэхжүүлэх хөтөлбөрийн гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд энэ хүрээнд нийт 18 сургалт, семинарыг амжилттай зохион байгуулж, хөтөлбөрт оролцогч талуудаас 782 хүнийг хамруулсан байна. Ингэснээр Уур амьсгалын ногоон сангийн Үндэсний хөтөлбөрийн талаарх ойлголт оролцогч талуудын дунд нэмэгдэж, Үндэсний хөтөлбөрийг нийтээр хүлээн зөвшөөрөхөд чухал нөлөө үзүүлсэн билээ.
- 2019: 10МВт-ын хүчин чадалтай Сүмбэр нарны цахилгаан станцын барилга угсралтын ажил дуусч, 2019 оны 3 дугаар сараас эхлэн цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлж эхлэв.
- 2019: Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд уг хөтөлбөрийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг эхлүүлээд байна. Ногоон санхүүжилтийн гуравдугаар чуулганыг зохион байгуулснаас гадна Сэргээгдэх эрчим хүчний 10-р форумыг ивээн тэтгэлээ.
- 2019: Гэр хорооллын бүсэд хэрэгжих "Мини Гридд/Офф Грид-Халаалтын бие даасан шийдэл" төсөл нь Уур Амьсгалын Ногоон Сангийн төсөл хөгжүүлэх санхүүжилтэд хамрагдсан. Уг төслийн хөгжүүлэлтийг хийлгэхээр Олон улсын зөвлөх багийг сонгон шалгаруулж ажиллуулж байгаа бөгөөд туршилтын төсөл 2020 онд хэрэгжих юм.

Эко Банк

Сумбэр Нарны Цахилгаан станцын бүтээн байгуулалт бүрэн дуусаж, Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системтэй 2019 оны 3-р сард холбогдлоо. Ашиглалтанд орсон цагаас эхлэн нийт 13,714 МВт эрчим хүчийг нийлүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 11,945 тонноор бууруулсан. Уг станц нь 20,000 гаруй өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах хүчин чадалтай бөгөөд 25 жилийн ашиглалтын хугацаанд жилд 171 сая литр ус хэмнэнэ.

Карбоны санхүүжилт

ХасБанкнаас Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд айл өрхүүд авсан бүтээгдэхүүнээ хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавих судалгаагаа үргэлжлүүлэв. Ингэснээр бид “МикроЭнержи Кредитс” компанитай хамтран карбон кредитийг НҮБ-ын Цэвэр хөгжлийн механизм болон Карбоны сайн дурын зах зээлд бүртгүүлэн карбоны нөхөн олговор хүлээн авах боломж бүрддэг. Нэгж карбон кредит гэдэг нь нэг тонн нүүрстөрөгчийн ялгарлын бууралт гэсэн үг юм. Карбон кредитийг байгууллагын нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх гэж буй корпорациуд болон нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтдоо хүрэхээр зорьж буй улс орнуудад зарж борлуулах боломжтой байдаг. ХасБанкны карбон кредитийн голлох худалдан авагч нь Шведийн Засгийн газар, Микрософт корпораци юм.

- Карбоны санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд
- 2009: Карбоны нөхөн төлбөрийг авч эхлэх зорилгоор МикроЭнержи компанитай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
 - 2011: Төслийн хүрээнд бий болсон карбон кредитийг Нүүрстөрөгчийн сайн дурын зах зээлд бүртгүүлснээр анхны карбоны нөхөн төлбөр хүлээн авав.
 - 2013: Цэвэр хөгжлийн механизмд Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн борлуулах төслүүдээ бүртгүүлснээр карбон кредитээ борлуулах боломж бүрдлээ.
 - 2015: ЭХХ-тэй бүтээгдэхүүн борлуулах төслийн үр дүнд бий болсон карбон кредитээ Шведийн Засгийн газарт худалдах гэрээ байгуулав.
 - 2016-2019: Төслүүдийн үр дүнд бий болсон карбон кредитийг Цэвэр хөгжлийн механизмд 2016 онд бүртгүүлснээс хойш нийт 350,000 карбон кредитийг бүртгүүлээд байна.

Тогтвортой Санхүүжилт

ХасБанк нь 2009 онд ЭкоБанкны хэлтсийг байгуулж, тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилласны үр дүнд бизнес эрхлэгчид болон иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчний технологиудыг санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээл олгож ирсэн.

2019 оны хувьд Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 2019 оны 9-р сараас эхлэн Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.

Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийн зорилго нь иргэдийн цахилгаан халаагуур, байшингийн дулаалга зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийн хэрэглээг нэмэгдүүлэх юм. Тус хөтөлбөр нь өрхийн түвшинд ногоон технологийн сонголтыг нэмэгдүүлэх ач холбогдолтой учраас ард иргэдэд ногоон технологийн хэрэглээний талаарх мэдээлэл түгээн ажиллаж байна.

- Тогтвортой санхүүжилтийн хүрээнд хийгдсэн онцлох ажлууд:
- 2009: Нидерландын Хөгжлийн Банкны (FMO) 6.5 тэрбумын төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр дамжуулан 1,778 айл өрхөд Эрчим Хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнүүдийг хэрэглээний зээлээр олгосон.
 - 2012-2019: Бизнес эрхлэгчдэд зориулсан Эко зээл олгогдож эхэлснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, борлуулагчид, хэрэглэгчид эрчим хүчний хэмнэлттэй болон сэргээгдэх эрчим хүчний бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй зээлээр дамжуулан худалдан авах боломж бүрдсэн.
 - 2012 онд Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангаас (GCPF) тогтвортой санхүүжилтийг дэмжих зорилгоор 20 сая ам долларын эх үүсвэр хүлээн авсан.
 - Тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2013 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны Монголын Тогтвортой

- Эрчим Хүчний Санхүүжилт (МонСЭФФ)-ийн 10 сая ам долларын эх үүсвэр хүлээн авсан.
- 2017 онд Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн хүрээнд 19.5 сая ам долларыг зээлийн зориулалтаар, 500,000 ам долларыг хөтөлбөр хөгжүүлэлтийн зориулалтаар тус тус хүлээн авсан.
- 2013 оноос эхлэн нийт 111.9 тэрбум төгрөгийг эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд олгож, хүлэмжийн хийн ялгарлыг 1,392,560 тонноор бууруулсан.
- 2014-2018: Даян Дэлхийн Уур Амьсгалын Хамтын Ажиллагааны Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч РеспонсАбилити байгууллагатай хамтран Эко автомашины зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шатахууны зардлыг хэмнэх авто машиныг зах зээл дээрхээс бага хүүтэйгээр санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж, 2018 онд хөтөлбөр дуусахад 1,067 харилцагчид 5.2 сая ам долларын санхүүжилт олгосон байна.
- 2018: ХасБанк нь Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран Ногоон бэлчээрийн төслийн зээлийн хөтөлбөрийг туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийн гол зорилго нь малын тоог цөөлөх замаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, малчдад хөнгөлөлттэй зээл олгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, цаашлаад амьжиргааг нь тогтвортой болгох юм.
- 2019: Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн Хөтөлбөрийг амжилттай эхлүүлж, зээлийн хүрээнд 9.0 сая ам долларын зээл, 1.0 сая ам долларыг хөтөлбөр хөгжүүлэлтэд зориулан авахаар УАНС-тай гэрээ байгуулаад байна. Тус зээлийн хөтөлбөрөөр дамжуулан 1,290.08 тонн хүлэмжийн хийг бууруулсан ба хөтөлбөр хэрэгжих хугацаанд хүлэмжийн хийн ялгарлыг 469,574 тонн хүртэл хэмжээгээр бууруулах боломжтой юм.

Эко Банк

Уур Амьсгалын Ногоон Сан

Уур Амьсгалын Ногоон Сан нь хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC)-ийн хүрээнд байгуулагдсан сан билээ. ХасБанк нь Монгол Улс дахь Уур Амьсгалын Ногоон Сангийн (УАНС) цор ганц магадлан итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага юм.

Уур Амьсгалын Ногоон Сан нь ХасБанкны тогтвортой санхүүжилтийн зорилтын хүрээнд хамгийн том хамтрагч байгууллага бөгөөд 2019 оны хувьд Эрчим Хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь УАНС-ийн Хялбарчилсан батлах загвараар төслийн саналаа батлуулсан анхны хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон. Харин, Сумбэр Нарны Цахилгаан станц нь 2019 оны 3-р сард Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системтэй холбогдсон нь УАНС-тай хамтран хэрэгжүүлсэн төслүүдээс амжилттай гүйцэтгэж дууссан эхний төсөл хөтөлбөр болсон юм.

ХасБанк болон Уур Амьсгалын Ногоон Сангийн хамтын ажиллагааны хүрээнд онцлох үйл явдлууд:

- 2016: ХасБанк нь хөгжиж буй орнуудаас Уур Амьсгалын Ногоон Сангийн хамгийн анхны магадлан итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон.
- 2016: FP 028: Уур Амьсгалын Ногоон Сангаас Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 19.5 сая ам долларын зээлийн эх үүсвэр, хөтөлбөр хөгжүүлэлт, хэрэгжүүлэх зорилгоор 500,000 ам долларын санхүүжилт авах гэрээ байгуулсан.
- 2017: FP 028: Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг ХасБанк хүлээн авсан нь УАНС-аас төслийн саналыг бүрэн олгосон анхны тохиолдол боллоо.
- 2017: ХасБанкны хоёр дахь төслийн санал болох FP 046: Сэргээгдэх Эрчим Хүчний Хөтөлбөрийг УАНС баталж, 8.65 сая ам долларын санхүүжилт хийхээр болов. Уг төслийн хүрээнд ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн анхны арилжааны банк болсон юм.
- 2018: ХасБанкны гурав дахь төслийн санал болох SAP004: Эрчим Хүчний Хэмнэлттэй Хэрэглээний Зээлийн хөтөлбөрийг УАНС баталж 9 сая ам долларын зээл, хөтөлбөр хөгжүүлэлтийн хүрээнд 1 сая ам долларын санхүүжилт хийхээр уг төслийг батлав. ХасБанк нь Хялбарчилсан батлах загвараар төслийн саналаа батлуулсан анхны хувийн хэвшлийн магадлан итгэмжлэгдсэн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллага болсон.
- 2018: Бэлэн байдлын дэмжлэгийн хөтөлбөрийн хүрээнд УАНС-ийн Үндэсний Эрх Бүхий Байгууллага болон Үндэсний зохицуулагчийн Уур Амьсгалын Ногоон сантай стратегийн чиглэлийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх, мөн улсын хэмжээнд хэрэгжих хөтөлбөрүүд бэлтгэхэд түнш байгууллагаар ХасБанк шалгаран, амжилттай ажилласан билээ.
- 2019: Сумбэр Нарны Цахилгаан станцын бүтээн байгуулалт 2019 онд бүрэн дуусч, Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системтэй 2019 оны 3-р сард холбогдсон. Ашиглалтанд орсон цагаас эхлэн нийт 13,714 МВт эрчим хүчийг ТБЭХС-д нийлүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 11,945 тонноор бууруулсан. Нарны цахилгаан станц нь 20,000 гаруй өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах хүчин чадалтай бөгөөд 25 жилийн ашиглалтын хугацаанд жилд 171 сая литр ус хэмнэх юм.
- 2019: Гэр хорооллын бүсэд хэрэгжих “Мини Гридд/ Офф Грид- Халаалтын бие даасан шийдэл” төсөл нь Уур Амьсгалын Сангийн төсөл хөгжүүлэх санхүүжилтэд хамрагдаж, туршилтын журмаар хэрэгжиж эхлэхэд бэлэн болоод байна. Уг төсөл нь Монгол улсад халаалтын бие даасан шийдлийг турших анхны төсөл болох юм.
- 2019: Уур Амьсгалын Ногоон Сантай хамтарсан Монголын Ногоон Санхүүжилтийн Корпорац (МНСК)-ийг байгуулах ажлын багийг бүрдүүлж, хамтран оролцогчид болох Монгол Улсын Засгийн газар мөн тэргүүлэгч банкуудтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах зэрэг бэлтгэл ажлууд хийгдээд байна.

ХасБанк нь Монгол улсын тогтвортой санхүүжилтийн тэргүүлэгч санхүүгийн байгууллагын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр цаашид үргэлжлүүлэн санхүүжилт олгон ажиллана.

Түмэн Амгалан Өргөө | Ногоон Барилга

ХасБанк нь 18,392 м2 талбай бүхий гурван үндсэн хэсгээс бүрдсэн Шинэ Монгол Харумафүжи дунд сургуулийн цогцолборын бүтээн байгуулалтыг 2018 оноос эхлэн Хүлэмжийн Хийг Бууруулах Бизнесийн Зээлээр дамжуулан санхүүжүүлж ирсэн. 2019 оны хувьд барилгын С хэсэгт байрлах сурагчдын хөгжлийн төв, спорт цогцолбор, номын сан, хоолны танхимыг стандартын дагуу, эрчим хүчний хэмнэлтэй загвараар барих ажлыг санхүүжүүлсэн.

Шинэ Монгол Харумафүжи дунд сургууль нь 1,140 сурагч, 65 багш, 30 гаруй ажилтантайгаар сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна. Шинээр баригдсан сургуулийн цогцолбор нь дулаан алдагдал бага цонх, дулаан эргүүлэн ашиглах рекулератортой систем, нарны зайн системийг суурьлуулж, шилэн фасадын хувь хэмжээг бууруулснаар нийт 47 хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгож чадсан. Эдгээрээс, сургуулийн дээвэр дээр байрлах цагт 60 МВт эрчим хүчийг үйлдвэрлэх чадалтай нарны зайн систем нь хамгийн их буюу 30 хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгож байна.

Уламжлалт барилгатай харьцуулахад ногоон технологийн шийдлүүдийг хэрэгжүүлж, 47 хувийн эрчим хүчний хэмнэлтийг бий болгосон нь сурагчиддаа нийгмийн хариуцлага, цаашлаад байгаль орчиндоо ээлтэй амьдрах талаар бодит үлгэр дууриалал болж байна.

Шинэ Монгол Харумафүжи дунд сургууль нь байгаль орчинд ээлтэй технологиор дамжуулан хэрхэн эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх боломжтойг харуулж, Монгол улсад сургууль, цэцэрлэгийн бүтээн байгуулалтын хүрээнд шинэ стандарт тогтоон ажиллаж байна.



Нийгмийн хариуцлага

БОЛОВСРОЛ

Санхүүгийн боловсрол олгох Афлатон хөтөлбөрийн хүрээнд нийт 10 сургууль, 140 сургагч багш, 5160 хүүхэд, түүний дотроос 230 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөтөлбөрөө хүргэлээ.

ХасБанкны ТУЗ-ийн гишүүн асан “Питер Морроугийн нэрэмжит ХасБанкны оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 4 дэх жилдээ зохион байгуулж 5 оюутанд тэтгэлэг олголоо.

“Шударга ёсыг Бадраах сан”-тай 11 дэх жилдээ хамтран ажиллаж, тус сангаас тэтгэлэгт хамрагдаж буй оюутнуудын санхүүгийн хэрэгцээг шийдэхэд дэмжлэг үзүүлэхээс гадна шилдэг оюутнуудыг ажилд авч байна.

“Цалинтай оюутан хөтөлбөр”-ийг анх удаа зохион байгуулж, шилдэг оюутнуудаа шалгаруулан Банканд мэргэжлийн дагуу дадлага хийх эрхийн батламжийг гардууллаа.

Global Money Week хөдөлгөөний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мөнгөний ухаалаг зарцуулалтыг хэвшил болгох, хуримтлал болон төлбөрийн картын ач холбогдлыг таниулан ойлгуулах, мөн мэргэжлээ хэрхэн сонгох вэ? сэдвүүдээр сургалт, лекц зохион байгууллаа.

Асрамжийн газрын 6-17 насны 50 хүүхдийг Банкандаа хүлээн авч, санхүүгийн боловсрол, зохих хэмжээний мэдлэг олгох хичээлийг “орлого ба зардал” сэдвийн хүрээнд зааж, хүүхдүүдэд мөнгөний үнэ цэн, хэрхэн зөв зохистой зарцуулах тухай ойлголтыг өглөө.



СОЁЛ УРЛАГ

Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран хүүхдүүдэд соёлын өвийн болон урлагийн боловсрол олгох “Миний мөрөөдөл” төслийг амжилттай хэрэгжүүлж, энэ хүрээнд мөрөөдлөө зураг баримлаар дүрслэх чиглэлээр 100 гаруй хүүхдэд сургалт зохион байгуулж, 3-14 насны багачуудын дунд бүтээлийн уралдаан зарлан, 600 бүтээл ирснээр шилдэг 15 бүтээлийг шалгаруулан шагналаа.



СПОРТ

Дуулиан 2020 заалны хөлбөмбөгийн тэмцээнийг 13 дахь жилдээ дэмжин, 5 сургуулийн 40 багийг ивээн тэтгэж оролцууллаа.

Хасын хүлэгүүд сагсан бөмбөгийн багийг үргэлжлүүлэн дэмжиж Үндэсний лигийн мөнгөн медаль хүртлээ.

Хас мэргэжлийн дугуйн клубын тамирчид маань дотоодын болон ОУ-ын тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцож, эх орныхоо нэрийг гаргаж байна.

Монголын Байт харвааны холбоо, Монголын Хонхтой Бөмбөгийн холбоодыг ивээн тэтгэж, Улсын аваргын тэмцээн зохион байгуулах, ОУ-ын тэмцээнд оролцоход нь дэмжлээ.



БАЙГАЛЬ ОРЧИН

Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг дэмжихэд зориулж энэ оны эхний хагас жилийн байдлаар 26 зээлдэгчид 6.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

2017 оноос хойш ХасБанк 138 ААН-д нийт 60.9 тэрбум төгрөгийн Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээл олгож, санхүүжүүлсэн эдгээр төслүүд нь жил бүр 74,6 сая киловатт эрчим хүч хэмнэж, 82,434 тонн хүлэмжийн хийг бууруулж байна.

Даян дэлхийн Уур амьсгалын Хамтын Ажиллагааны сан /GCPF/-тай хамтран Харилцагчийн Нийгэм байгаль орчны эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэн нэвтрүүллээ.



Зохистой Засаглал

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭ

Зохистой засаглал нь ХасБанкны байгууллагын соёл, үнэт зүйлсийн салшгүй хэсэг бөгөөд банкны бизнесийг тогтвортой байдлаар амжилттай хөгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон нэгдмэл сонирхолтой бусад талуудад урт хугацааны үнэ цэнэ бий болгох, ХасБанканд итгэх итгэлийг бэхжүүлэх үндэс суурь болж ирсэн. Бид Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, гадаад болон дотоод, том болон жижиг зэрэг бүх хувьцаа эзэмшигчид тэгш эрхтэй байх, бүх шатандаа тайлагнах, мэдээлэл өгөх, ил тод байдлыг хангах, нэгдмэл сонирхолтой бүх талуудын өмнө хариуцлага хүлээх, шийдвэр гаргалтад хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримтлах, олон улсын жишигт нийцсэн засаглалын хэм хэмжээг хэрэгжүүлэх дээр суурилсан зохистой сайн засаглалыг хөгжүүлж ажиллахыг эрмэлздэг.

ХасБанк нь Монгол Улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан арилжааны банк бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна банкны салбарын зохицуулагч Монголбанк (Төв Банк)-аас гаргадаг засаглалын дүрэм, журмын заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй. Бид “Банкны зохистой засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэх журам”-ын дагуу зохистой засаглалын тайлан гаргаж, Монголбанканд хүргүүлж тайлагнадаг.

2019 онд ХасБанкны ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь зохистой засаглалын зарчмуудын дагуу ажиллах, засаглалын тогтолцоог үнэлж дүгнэх, цаашид сайжруулах дээр анхаарч ажилласан. Энэхүү тайланд Компанийн засаглал, хянан нийцүүлэлтийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааг танилцуулсан болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2019 онд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар Банкны жилийн үр дүн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн төсвийг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Банкны өсөлтийг хангах үүднээс 2018 оны ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага шийдвэрүүдийн талаар мэдээлэл солилцож, хувьцаа эзэмшигчдийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангаж, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргалтыг дэмжиж ажилласан.

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ

ХасБанк нь Монгол Улсын санхүүгийн томоохон компаниудын нэг болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн бүрэн эзэмшлийн охин компани. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь олон улсын санхүүгийн байгууллагууд, дотоодын болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, төрийн бус байгууллагууд болон хувь хүмүүсээс бүрдсэн хувьцаа эзэмшигчидтэй.

Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Банкны дотоод журмын дагуу толгой компани ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Банкны хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд хамрагдахаар тусгайлан заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг. ТУЗ нь Банкны стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Банкныг стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Банкны үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсөв, мөн Эрдэнэт Хүмүүн, Эх Дэлхий, Эрүүл Ашиг гэсэн эрхэм зорилгын хүрээнд Банктай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг.

ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь ТУЗ-өөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу ТУЗ-ийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулдаг, мөн ТУЗ-өөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулж болдог.

Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Банкныг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй. Зохистой засаглалын тогтолцооны хүрээнд ТУЗ-д шууд тайлагнадаг дотоод аудитор болон компанийн нарийн бичгийн даргыг удирдлагын түвшний албан тушаалд ажиллуулдаг.

Зохистой Засаглал

ТУЗ-ИЙН МАНЛАЙЛАЛ

ТУЗ-ийн бүтэц

ТУЗ-ийн гишүүн бүрийг асуудлын хэлэлцүүлэгт оролцуулж үр дүнтэй үйл ажиллагааг хангах, нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж, түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргахад ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн тоо, чадвар, мэргэшсэн дадлага туршлага, гүйцэтгэх удирдлагын төлөөлөл, хараат бус гишүүдийн оролцоо нь нэн чухал ач холбогдолтой. Банкны тулгарч буй асуудлуудыг ойлгож шийдвэрлэх, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглүүлэхэд ТУЗ-ийн гишүүдийн банкны салбарын мэдлэг боловсрол, туршлага, мэргэжлийн ур чадвар, жендер, харъяаллын тэнцвэртэй байдал чухал гэдгийг хүлээн зөвшөөрч, Банкны стратегийн чиглэлтэй уялдуулан ТУЗ-ийн бүрэлдэхүүн, бүтцийг үнэлж нягталж, өөрчлөх шаардлагатай эсэх талаар дүгнэлт зөвлөмж гаргадаг.

#	Нэр	Албан тушаал	Төлөөлөл
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	Хараат бус
2	Гүмэнжавын Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	-*
3	Нямтайширийн Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	Монголын Алт (МАК) Корпораци
4	Мелисса Мой Тиан*	ТУЗ-ийн гишүүн	ОУСК
5	Андрэеж Витак	ТУЗ-ийн гишүүн	ЕСБХБ
6	Риожи Нишимура	ТУЗ-ийн гишүүн	ОРИКС Корпораци
7	Ив Жако	ТУЗ-ийн гишүүн	Канадын Үндэсний Банк
8	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	Ронок Партнерз
9	Баянсаны Уламбаяр	Хараат бус гишүүн	Хараат бус
10	Нираж Вэдва	Хараат бус гишүүн	Хараат бус
11	Морис Лам*	Хараат бус гишүүн	Хараат бус

*Дүрэмд заасны дагуу

*ТУЗ-ийн шийдвэрээр 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түр томилогдсон гишүүд

ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын үүрэг

ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын үүргийг өөр өөр хүн гүйцэтгэх ба энэ талаар Банкны дүрэмд тодорхой заагдсан байдаг. ТУЗ-ийн дарга болон Банкны Гүйцэтгэх захирлын хооронд үр дүнтэй ажлын харилцаа, эрх мэдлийн тэнцвэртэй байдал, тайлагналт, шийдвэр гаргалтад бие даасан байдал байдаг.

2019 онд ТУЗ-ийн даргаар 2004 оноос хойш ажилласан Чулууны Ганболд үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, оронд нь Санжай Гүпта ТУЗ-ийн даргаар томилогдсон. Санжай Гүпта нь Олон улсын санхүүгийн корпорациас нэр дэвшиж 2017 оны 3 дугаар сараас хойш ТУЗ-ийн гишүүнээр ажилласан. ТУЗ-ийн даргаар томилогдсоны дараа Санжай Гүпта-гийн Олон улсын санхүүгийн корпорацийг төлөөлөх мандат дуусгавар болж хараат бус болсон.

Мөн Гүйцэтгэх захирлаар 2014 оноос хойш ажилласан Магваны Болдоо үүрэгт ажлаа хүлээлгэн өгч, оронд нь Иргэдийн банкны Ерөнхий захирлаар ажиллаж байсан Гүмэнжавын Цэвэгжав 2019 оны 5 дугаар сард Гүйцэтгэх захирлаар шинээр томилогдсон. Г.Цэвэгжав нь ХасБанканд 2011 оноос хойш удирдлагын албан тушаалд ажилласан.

ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, ТУЗ-өөс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үнэлэх ажлыг удирдах, ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж боловсруулах, хурлаар асуудал бүрийг зохистой түвшинд хэлэлцэж, гишүүн тус бүрээс хэлэлцүүлэгт оролцож санал гаргах явдлыг дэмжин ажилладаг. ТУЗ-ийн дарга шийдвэр гаргах явцад ТУЗ-ийг удирдаж, ТУЗ-ийн багийн ажиллагааг хангаж ажилладаг. Үүнээс гадна ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захирлыг чиглүүлж, удирдлага зөвлөмжөөр хангаж, хяналт тавьж ажилладаг.

Гүйцэтгэх захирал нь банкны өдөр тутмын удирдлага, үйл ажиллагааг удирдаж, ТУЗ-өөс батлагдсан стратеги, зорилт, бодлогыг хэрэгжүүлж ажилладаг. Гүйцэтгэх захирал нь стратегийн болон бизнесийн төлөвлөгөө, бүтэц зохион байгуулалт, хяналтын систем, дотоод дүрэм журмыг боловсруулах ажлыг хариуцдаг.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2 жилийн хугацаатай сонгодог. ТУЗ-ийн гишүүд дахин сонгогдох эрхтэй. Сонгуулийн хугацаа дуусах үед гишүүн үүрэгт ажлаа өгнө эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин сонгогдоно. ТУЗ-д орон тоо гарах эсхүл Дүрэмд заасан бусад нөхцөл байдал үүсэх тохиолдолд ТУЗ-ийн гишүүнийг ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, сонгох, улируулан сонгох, чөлөөлөх журам нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журам болон ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах журамд тусгагдсан байдаг. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн Яамны хамтарсан тушаалаар батлагдсан “Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөх үүднээс 2017 онд Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, хараат бус гишүүний талаарх тусдаа заалт оруулсан.

ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, гишүүдийг сонгон шалгаруулах журам боловсруулах, ТУЗ-ийн гишүүнд, түүнчлэн хараат бус гишүүнд нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан эсэхийг үнэлэн шалгаж, ТУЗ-д зөвлөмж гаргаж танилцуулах асуудлыг хариуцдаг.

Хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг Банкнаас хүргүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай с мэдэгддэг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос ТУЗ-ийн хурлаар сонгодог.

ТУЗ-ийн дараах гишүүдийг 2020 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох эсхүл улируулан сонгохоор оруулж батлуулна.

- Мелисса Мой Тиан (сонгох)
- Морис Лам (сонгох)
- Риожи Нишимура (улируулан сонгох)
- Ив Жако (улируулан сонгох)
- Баянсаны Уламбаяр (улируулан сонгох)

Зохистой Засаглал

ТУЗ-ийн хурал

ТУЗ нь Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. ТУЗ-ийн ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгсэлээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг.

2019 онд ТУЗ-ийн 4 ээлжит ба 1 ээлжит бус хурлыг Улаанбаатар хотод хуралдуулсан. Хурлын ирцийг дараах хүснэгтээр харуулав.

#	Огноо	Хурал	Ирц
1	2019 оны 3-р сарын 27	ээлжит	10/10
2	2019 оны 3-р сарын 28	ээлжит бус	9/9
3	2019 оны 6-р сарын 19	ээлжит	11/11
4	2019 оны 9-р сарын 18	ээлжит	9/11
5	2019 оны 11-р сарын 29	ээлжит	10/11

2019 онд ТУЗ нь 46 тогтоол шийдвэр гаргасан ба үүнээс 12 тогтоол шийдвэрийг ТУЗ-ийн хурлыг хуралдуулалгүйгээр эчнээ санал хураалтаар гаргасан болно.

Банкны гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож Банкны бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон банкны үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

ТУЗ-ийн хурлын үеэр албан ёсоор харьцаж тайлагнахаас гадна ТУЗ-ийн гишүүд Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүдтэй тогтмол албан бус байдлаар харилцах боломжтой байдаг нь удирдлагын баг болон ТУЗ-ийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг, мэдлэг туршлага солилцох үйл ажиллагааг хангадаг.

ТУЗ-ийн гишүүдийн цалин

ТУЗ-ийн гишүүд ТУЗ, хорооны хуралд оролцох болон бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой цалин авдаг. ТУЗ-ийн гишүүний цалингийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог.

Зохистой засаглалын зарчмын¹ дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй тогтоодог.

ТУЗ-ийн гишүүнд хуралд оролцсонтой холбоотой зардлын нөхөн олговор олгодог. Нөхөн олговор олгох журмыг ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журамд заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүн зөвлөх үйлчилгээний хөлс болон өөр бусад шагнал урамшуулал авдаггүй.

ТУЗ-ийн хороод

ХасБанкны ТУЗ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилготой. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь тав буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй.

ТУЗ-ийн гишүүдийн сургалт

Зохистой засаглалын зарчим, Компанийн хуулийн 75.8 дугаар заалтын дагуу ТУЗ-ийн гишүүд зохистой засаглалын сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авах үүрэгтэй. 2019 онд шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд сургалтанд хамрагдсан.

Банкны стратеги, үйл ажиллагаа, дотоод хяналтын тогтолцооны талаар болон бусад мэдээлэл өгөх зорилгоор шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдэд удирдлагын багтай уулзах хөтөлбөр зохион байгуулдаг. Шинэ гишүүд Банкны Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журам, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын заалтуудтай танилцаж, хүлээн зөвшөөрч буйгаа гарын үсэг зурж мэдэгдэх үүрэгтэй.

Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу ТУЗ-ийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг, ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх захирал ТУЗ-ийн Аудит, Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүнээр ажилладаггүй.

Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог ба 2019 онд байнгын хороодын ээлжит хурлыг 4 удаа улирал бүр хуралдуулсан. Ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг онлайн болон **мэдээллийн** бусад хэрэгсэлээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар зөвлөмж гаргаж ажилладаг.

Зохистой Засаглал

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Уг хороо дараах үндсэн үүрэг хариуцлагатай. Үүнд: (i) ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох, (ii) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах, эдгээр болно. Хорооны дүрмийг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материалаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай. Эрсдэлийн удирдлагын хорооны дүрмийг 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг. Аудитын хорооны дүрмийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан.

ГИШҮҮД²

Майкл Мадден, дарга
Мелисса Мой Тиан
Риожи Нишимура
Андрэж Витак
Санжай Гүпта
Нямтайширийн Цэлмүүн

ГИШҮҮД³

Риожи Нишимура, дарга
Ив Жако
Нямтайширийн Цэлмүүн
Баянсаны Уламбаяр (*хараат бус гишүүн*)
Нираж Вэдва (*хараат бус гишүүн*)
Морис Лам (*хараат бус гишүүн*)

ГИШҮҮД⁴

Морис Лам (*хараат бус гишүүн*), дарга
Ив Жако
Андрэж Витак
Мелисса Мой Тиан
Нираж Вэдва (*хараат бус гишүүн*)
Баянсаны Уламбаяр (*хараат бус гишүүн*)

СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛ БА ТОЛИЛУУЛГА

Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхолын зөрчлийн журам нь сонирхолын зөрчлийг тодорхойлж, сонирхолын зөрчлийг мэдэгдэж шийдвэрлэх журмыг тогтоодог. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүд, ажиллагсад нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хувийн, санхүүгийн болон бусад сонирхол нөлөөлж болзошгүй тохиолдолд, түүнийгээ мэдэгдэж мэдээлэх;
- ТУЗ-ийн гишүүд Банкаас хийх гэж буй аливаа хэлцэлтэй холбоотой ямар нэг сонирхолын зөрчилтэй бол энэ талаар тухайн хэлцлийг авч хэлэлцэж буй ТУЗ-ийн хурал дээр мэдэгдэж мэдээлэх,
- ТУЗ-ийн гишүүн аливаа хэлцэл, ажил үйлчилгээ, саналд шууд ба шууд бус сонирхолтой бол ТУЗ-өөр тухайн асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргахад санал хураалтад оролцохгүй, ирц бүрдүүлэхгүй байх, эдгээр болно.

2019 онд ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд толилуулгын хуудсыг бөглөж, сонирхолын зөрчлийн талаар мэдэгдэж мэдээлсэн. Ил тод байдлыг илүү хангах үүднээс толилуулгын хуудаснуудыг ТУЗ-ийн онлайн портал дээр байршуулж эхэлсэн.

ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхолын зөрчлийг мэдэгдэж мэдээлэх үүрэгтэй.

ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭ

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүн тус бүрийн үнэлгээ хийдэг.

Банкны ТУЗ нь 2019 онд тус үнэлгээгээ хийсэн болно.

АУДИТ БА ТАЙЛАГНАЛ

ТУЗ нь Банкны санхүүгийн тайлан үнэн зөв бэлтгэгдсэн, холбогдох хууль тогтоомж, банкны салбарын зохицуулагч байгууллагын шаардлага болон хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж баталдаг. Банкны удирдлага нь ТУЗ-өөр батлуулахаар санал болгосон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-д мэдээлэл тайлбар өгөх, ТУЗ-ийг үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт хийж шийдвэр гаргах боломжоор хангах үүрэгтэй.

ТУЗ нь хөндлөнгийн аудиторыг сонгох, томилох, тодорхой хугацааны дараа солих өөрчлөх үүрэгтэй ажилладаг. 2014 онд Эрнст Янг компанийн оронд хөндлөнгийн аудитороор томилогдсон Делойт компани нь 2019 оны аудит хийхээр дахин томилогдсон.

Олон улсын үнэлгээ

2019 онд тус Банкны рейтингийн агентлагууд болох Мүүдиз болон Фитч Рейтинг үнэлгээ хийж, үр дүнд нь ХасБанкны гадаад рейтинг өссөн дүнтэй гарсан. Банк ялангуяа 2017 онд Активын чанарын үнэлгээ (AQR) хийлгэсэн, эдийн засгийн эерэг өсөлтийн үр дүнд улс орны рейтинг өссөн зэрэг нөхцөл байдалд рейтингийн агентлагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, ажил хэрэгчээр харилцаж ирлээ.

СҮҮЛИЙН ҮЕИЙН ҮЙЛ ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ:

- 2018 оны нэгдүгээр сард Мүүдиз манай рейтингийг Саа1-ээс В3 буюу тогтвортойгоос эерэг болгон сайжруулсан.
- 2019 оны 12 дугаар сард Мүүдиз манай банкны өмнөх үнэлгээг дахин нотолсон.
- 2018 оны 12 дугаар сард Фитч Рейтинг манай урт хугацааны үнэлгээг В- аас В болгон сайжруулсан.
- 2019 оны 9 дүгээр сард Фитч Рейтинг манай өмнөх үнэлгээг дахин нотолсон.

Moody’s

“Мүүдиз” олон улсын үнэлгээний байгууллага (www.moodyс.com) нь дэлхийн нийт улс орны зээлжих чадвар болон томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад санхүүгийн зэрэглэл тогтоогч.

	DEC 2019
Оролцогч талуудын эрсдэлийн үнэлгээ	B2/NP
УХ/БХ гадаад валютаар татан төвлөрүүлсэн хөрөнгө	Сaa1/NP
УХ/БХ төгрөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө	B3/NP
Зээлжих чадварын үнэлгээ	B3
Үнэт цаас гаргагчийн үнэлгээ	B3
Хандлага	Тогтвортой

FitchRatings

Фитч Үнэлгээний Компани (www.fitchratings.com) нь Ази Номхон далайн бүс төдийгүй дэлхийн зах зээл дээр тэргүүлдэг зээлжилт болон санхүүгийн зэрэглэл тогтоогч.

	NOV 2019
УХ гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	В/Тогтвортой
БХ гадаад валютаар хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	В
УХ төгрөгөөр хүлээсэн үүргийг биелүүлэх зэрэглэл	В/Тогтвортой

Санхүүжүүлэгч, түнш байгууллагууд



ОУСК бол Дэлхийн банкны группын гишүүн, хөгжиж буй зах зээл дэхь хувийн хэвшлийг дэмжих зорилттой дэлхийн хамгийн том хөгжлийн чиглэл бүхий байгууллага юм. ОУСК-ийн гол зорилго нь хувийн хэвшил зориулсан санхүүгийн эх үүсвэрийг дийлэх, ядууралд нэрвэгдсэн хүмүүст ажлын байр бий болгох бизнесийг дэмжих замаар ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломжийг бий болгох явдал юм. ОУСК нь ХасБанк-ы хувьд хувьцаа эзэмшигч бөгөөд ОУСК-ийн Капитализаешн Сангаас хоёрдогч өглөгөө, ВИДФ сангаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих эх үүсвэр зэрэг олон төрлийн урт хугацааны санхүүжилтийг буй болгож өгсөн юм.



Нидерландын Хөгжлийн Санхүүгийн Компани (“ФМО”) нь Голландын засгийн газрын олохийн хувь эзэмшдэг гурван А үнэлгээтэй, хөгжлийн банк юм. ФМО нь гарааны бизнесийн хөгжлийг эдийн засгийн тогтвортой өсөлтийн түлхүүр гэж үздэг бөгөөд ингэснээр улмаар ард түмний амьжаргааны түвшин сайхрах болно. ФМО-ийн үндсэн чиг үүрэг бол эрсдэлийн хөрөнгө оруулалтаа урт хугацааны төслүүдэд, хэтийн ирээдүйд ан тус нөлөө бүхий салбарт чиглэсэн урт хугацааны хөрөнгө оруулалт хийх явдал юм. 2019 оны 12-р сард ФМО нь ХасБанканд 100 сая ам.долларын хамтын санхүүжилтийн эх үүсвэр олгох хэлцэлийг амжилттайгаар байлгуулаа.

responsAbility

2003 онд байгуулагдсан, ResponsAbility Investment AG (“ResponsAbility”) нь бие даасан, хөгжингүй эдийн засгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр мэргэшсэн, дэлхийд тэргүүлэгч хөрөнгийн удирдлагын компани юм. ResponsAbility нь ихэвчлэн хувицаа нь олон нийтэд арилжаалагддаггүй буюу хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компаниудад зээл болон үндсэн хөрөнгийн санхүүжилтийн аль алиныг нь өгдөг. ResponsAbility нь одоогоор ХасБанк-д бичил эсвэл жижиг ангилалтай бизнесүүдийг дэмжих зорилгоор, мөн экологид ээлтэй бизнесийг дэмжих зорилгоор хоёр эх үүсвэрийг олгоод байна.

KFW DEG

1962 онд байгуулагдсан DEG нь 2001 оноос хойш KfW группын бүрэн эзэмшлийн охин компани бөгөөд хөгжиж буй зах зээл дээр зээл эсвэл өөрийн хөрөнгө хэлбэрээр урт хугацааны эх үүсвэрийг олгодог. DEG нь хөгжиж буй болон шилжилтийн үеийн орнуудад гарааны бизнес эрхлэх санаачлагыг дэмжиж, санхүүжүүлж ажилладаг. DEG нь өөрийн хөрөнгө оруулалтынхаа, тухайн улсын хэтийн хөгжлийн нөлөөнд ихээхэн ач холбогдол өгдөг ба урт хугацааны харилцааны туршид ХасБанкаар дамжуулан Монгол Улсын эдийн засагт ЖДҮ-ийн сегментийг санхүүжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг буй болгосон.

Swedfund

SwedFund бол 1979 онд байгуулагдсан, Шведийн засгийн газрын бүрэн мэдэлд байдаг хөгжлийн санхүүгийн байгууллага юм. Swedfund-ийг Шведийн Бизнес, инновацийн яам хариуцдаг бөгөөд эрхэм зорилго нь хөгжиж буй орнуудын ирээдүйн хийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад гол хувь нэмэр оруулж буй ажлын байр бий болгодог хувийн хэвшлийн салбар бизнесийг тогтвортой санхүүжүүлэх, хөгжүүлэх явдал юм. ХасБанк өөрийн бичил болон жижиг эзэлдэгчдийг дэмжих зорилгоор SwedFund -с 2021 онд дуусах эх үүсвэрийг авсан байна.



Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банк (“IBEC”) нь 1963 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. IBEC нь түүний гишүүн найман орны аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн хөгжил, гадаад худалдааны харилцааг дэмжихэд чиглэдэг. 2019 оны 12-р сард байгуулагдсан нийт 100 сая ам.долларын хамтын ажиллагааны санхүүжилтийн гэрээ хэлэлцээрт, экспорт импортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн санхүүжилтийг дэмжих эх үүсвэрийн хэсэгт ХасБанк ба IBEC гарын үсэг зурав.



Ногоон Уур амьсгалын Сан (“GCF”) нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн хүрээний конвенцийн хүрээнд 2010 онд байгуулагдсан сан юм. GCF нь хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлаж, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицохыг, ирээдүйд уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн замыг бий болгох талаар улс орнуудыг дэмжиж ажилладаг. Санхүүжилтийг итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжүүдээр дамжуулан олгодог бөгөөд ХасБанк нь Монгол улс дахь магадлан итгэмжлэгдсэн арилжааны цорын ганц банк юм.



Европын сэргээн босголт, хөгжлийн банк (“ЕСБХБ”) нь олон улсын хөгжлийн хөрөнгө оруулалтын банк бөгөөд 1991 онд байгуулагдсан санхүүгийн байгууллага юм. ЕСБХБ нь зөвхөн суурин үйл ажиллагаагаа явуулж буй орнуудад зээл олгодог бөгөөд 2006 оноос хойш дэлхийн 40 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулж байна. Үндсэн чиг үүрэгтээ байгаль орчны хариуцлага хүлэсэн анхны олон улсын банк бөгөөд 40 хувийн санхүүжилтээ ногоон хөрөнгө оруулалтад зориулах хэтийн зорилтондоо 2017 онд хүрчээ. ХасБанк болон ЕСБХБ-ны хоорондын урт хугацааны харилцаат хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалт, эх үүсвэр болон худалдааны санхүүжилт зэрэг багтана.



Symbiotics бол хөгжиж буй орнуудын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл аж ахуй (БХЖДҮ) болон дундаж болон түүнээс доош орлоготой өрхийг дэмжих, санхүүжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч хөрөнгө оруулалтын компани юм. Тус компани нь хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээний төвлөрөлийг буй болгосон байдаг ба хувийн хэвшлийн эх үүсвэрийн удирдлага, зөвлөх үйлчилгээ зэргийг санал болгодог юм. Одоогоор байлдаар олон тооны эзэлдэгчдийг хамарсан 20 гаруй санг удирддаг бөгөөд 2019 онд ХасБанк болон Symbiotics харилцаа нь одоо байгаа эх үүсвэрүүдээ ахин санхүүжүүлэх замаар улам бэхжиж улмаар нэмж хоёр эх үүсвэр авсан байна.



Хөгжиж буй дэлхийн зах зээл (“DWM”) нь АНУ-д суурилсан хөрөнгө оруулалтын удирдлагын компани бөгөөд эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлтэй зөвхөн хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг байгууллага юм. 1994 онд байгуулагдсан үүсгэн байгуулагчидын хувийн өмчлөлтэй ба Голланд, Германи, Япон гэх мэт олон улсын зах зээлээс өнгөөр хүртэл 1.7 тэрбум ам.долларын санхүүжилтийг босгоосон бөгөөд тэдгээрийн хөрөнгө оруулалтыг удирддаг. 2019 онд ХасБанк DWM-ийн удирддаг Европын хөрөнгө оруулалтын сангуудтай байгуулсан зээлийн өр төлбөрөө дахин санхүүжүүлэх ажлыг амжилттай хийлээ.



Proparco бол хувийн хэвшлийн хөгжилд чиглэсэн Францын Хөгжлийн Агентлагын (“ФАТ”) эзэмшдэг томоохон компани бөгөөд эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн гол чиглэл баримталдаг. PROPARCO нь дэлхийн 80 оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 500 гаруй үйлчлүүлэгчтэй, эдгээрт нь жижиг дунд бизнес эрхлэгчдээс бичил санхүүгийн байгууллагуудыг багтаасан бүс нутгийн банкны байгууллагуудад орох бөгөөд 2019 онд ХасБанкны хамтын санхүүжилтээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг олгогчдийн нэг юм.



Финляндын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны сан (“FinnFund”) нь Финландын төрийн болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилтэй хөгжлийн санхүүгийн компани юм. Finnfund нь эрсдэлийн хөрөнгө, урт хугацааны зээл, хөгжиж буй орнуудын хэрэгжүүлж буй төслүүдийн санхүүжилтийг олгож, улмаар тогтвортой хөгжлийг хангах төслийн хөрөнгө оруулалтынхаа бүх ашгийг ахин санхүүжилтээр эргэж олгох бодлого баримталдаг. Finnfund болон ХасБанктай харилцаагаа 2019 онд гүйцэтгэсэн хамтын санхүүжилтээр бэхжүүлж бататгаан байна.



ОПЕК-ийн Олон улсын хөгжлийн сан (“OFID”) нь 1976 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. OFID нь дэлхий даяар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төр, хувийн болон худалдааны салбарын санхүүжилтийг олгодог. 2019 оны 12-р сард байгуулагдсан нийт 100 сая ам.долларын хамтын ажиллагааны санхүүжилтийн хэлэлцээрт, худалдааны санхүүжилтийг дэмжих эх үүсвэрийн хэсэгт ХасБанк ба OFID тохиролцонд хүрж гэрээг эцэслэв.



Дэлхийн цаг уурын түншлэлийн сан (“GCPF”) нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар Германы Холбооны засгийн газрын санаачилгаар хаалттай санхүүжүүлтийн хэлбэрээр байгуулсан хөрөнгө оруулалтын сан юм. GCPF сан нь өөрөө хугацаагүй бөгөөд орон нутгийн санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчид болон хувийн өрхүүдэд чиглэсэн хүлэмжийн хийг бууруулах төслийг санхүүжүүлдэг.



Азийн хөгжлийн банк (“АХБ”) нь 1966 онд байгуулагдсан, 1991 оноос хойш Монгол Улсыг эгнээндээ багтаасан 68 гишүүн бүхий бүс нутгийн хөгжлийн банк ба боловсрол, хүрэлэн буй орчин, дэд бүтэц, бүс нутгийн хамтын ажиллагаа, санхүүгийн салбарт гэсэн үндсэн чиглэлтэй үүсч байсан бол хувийн хэвшлийн санхүүжилт сүүлийн 10 жилд ихээхэн хэмжээгээр өсч, одоо үндсэн хөрөнгийн 20 орчим хувийг эзэлж байна. 2019 онд ХасБанк нь эмэгтэй болон хөдөө орон нутгийн бизнес эрхлэгчдэд чиглэсэн зээл олгох зорилгоор АХБ-аас 30 сая ам.долларын 5 жилийн хугацаатай эх үүсвэрийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

Triodos Investment Management

Triodos Investment Management BV (“Triodos”) нь Тридос Банкны эзэмшлийн охин компани ба уг банк нь нийгэм, экологийн үр өгөөжд чиглэсэн бизнесийн тогтвортой хөгжлийг сурталчлах зарчим бүхий банкны анхдагчдын нэг юм. Дэлхий даяар 750 гаруй үүсвэрийн шууд хөрөнгө оруулалттай 4.6 тэрбум еврогийн удирдаж буй хөрөнгө бүхий, тус байгууллагын хөрөнгө оруулалт нь эрчим хүч, санхүүгийн орлоцоо, тогтвортой хөдөө аж ахуй, хувь эзэмших болон бонд зэрэг өргөн хүрээний стратегийдыг хамардаг. 2019 оны байдлаар ХасБанк нь Тридос-н хувьд эзэлийн эх үүсвэр болон өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын аль алинаар нь санхүүжилт авсан харилцагч юм.



Инкофин хөрөнгө оруулалтын удирдлагын компани (Инкофин ХӨМ) нь хөгжиж буй орнуудын бичил санхүүгийн олгодог бизнесүүдийг дэмждэг хөрөнгө оруулалтын сангуудад зөөлөгдө байгууллага юм. Бичил санхүүгийн бизнесүүд нь банк тогтмол хүрж ажиллах боломжгүй хүмүүс, хувиараа бизнес эрхлэгч нарт зээл, хадгаламж, даатгалын зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Бичил санхүүгийн чиглэл дотоо хөдөө орон нутгийн санхүүжилтэнд мэргэшсэний хувьд Инкофин ХӨМ-ийн гол зорилго бол илүү аюллагдмал орон нутагт амьдардаг, мөн хөдөө аж ахуйн салбарт идэвхтэй ажилладаг хүмүүст хүрж дэмжлэг үзүүлэх явдал юм. Инкофин ХӨМ 40 гаруй орны 152 байгууллагыг санхүүжүүлж, дэмжиж ажилладаг.



Швейцарийн хөрөнгө оруулалтын сан (“SIFEM”) нь Швейцарын засгийн газрын 2005 онд байгуулагдсан хөгжиж буй орнуудыг дэмжиж зорилттой санхүүгийн байгууллага юм. SIFEM нь ажлын байр бий болгож буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөгжиж буй орнуудад урт хугацааны, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгодог. Тус санг 2016 оноос хойш ХасБанктай амжилттай хамтран ажиллаж, идэвхитэй харилцааг бий болгосон хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөх Obviam удирддаг.



АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпораци (“DFC” хуучнаар OPIC) буюу Америкийн хөгжлийн банк нь 1971 оноос үүсэлтэй байгууллага юм. DFC нь хөгжиж буй дэлхийн өмнө тулгараад байгаа хамгийн хүнд сорилтуудын шийдлийг санхүүжүүлэх зорилгоор хувийн хөрөнгө оруулагч нартай түншилж хамтран ажилладаг ба эдгээр сорилтуудад ажлын байр бий болгогч жижиг бизнес эрхлэгчид, эмэгтэй гарааны бизнес эрхлэгчдийг авч үздэг болно. ХасБанк нь эмэгтэй бизнес эрхлэгч үйлчлүүлэгчдийг дэмжих зорилгоор 2017 онд DFC санхүүжилтийг авсан байна.



SaixaBank, S.A бол Иберийн хойгын улсуудын иргэдийн банкны салбарт тэргүүлэгч санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг групп юм. SaixaBank олон улсын банк (CIB) нь дэлхийн хэмжээнд өргөн сүлжээтэй бөгөөд үйл ажиллагааны хоёр тулгуур гол багана нь гадаад худалдаа, олон улсын төлбөр тооцооны бүтээгдэхүүнийг санал болгодог ба үүндээ орон нутгийн санхүүгийн байгууллаар дамжуулж үйлчилгээ явуулдаг. ХасБанк нь 2017 оноос хойш хэрэглэгчидээ богино хугацааны худалдааны санхүүжилтийг тогтмол олгож байна.

Корреспондент банкууд

	Канадын Үндэсний Банк Монреаль, Канад	BNDCCAMMINT
	Австрали ба Шинэ Зеландын Банк Групп Мельбурн, Австрали	ANZBAU3M
	БНХАУ-ын Хөдөө аж ахуйн Банк Өвөр Монгол дахь салбар, БНХАУ	ABOCCNB050
	БНХАУ-ын Аж үйлдвэр ба Худалдааны Банк Өвөр Монгол дахь салбар, БНХАУ	ICBKCNBJNMA
	Хятадын Үндэсний Банк Хонконг дахь салбар, Хонконг	BKCHHKHH
	АйнЖи Бельги Брюссель, Бельги	BBRUBEBB010
	Коммэрз Банк Франкфурт, Герман	COBADEFF
	ХайпоВэрэйнс Банк Мюнхен, Герман	HYVEDEMM
	ӨүСиБиСи, Сингапур ӨүСиБиСи Өмнөд Төв , Сингапур	OCBCSGSG
	Райффэйзэн Банк Москва, ОХУ	RZBMRUMM
	Сбер Банк Москва, ОХУ	SABRRUMM
	ТрансКапитал Банк Москва, ОХУ	TJSCRUMM
	Токио Банк Мицубиши, юэФЖи Токио, Япон	BOTKJPJT
	Сүмитомо Мицүи Банк Корпораци Токио, Япон	SMBCJPJT
	Күүкмин Банк Сөүл, Солонгос	CZNBKRSE
	КэйИБи Хана Банк Сөүл, Солонгос	KOEXKRSE

Мэдээллийн технологи, цахим аюулгүй байдал



ХАСБАНКНЫ ХЭВИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Монголбанкны “Мэдээллийн Технологийн Шалгуур Үзүүлэлтийн Журам”-д заасны дагуу банк олон улсын мэдээллийн технологийн засаглал удирдлагын COBIT5 тогтолцоонд суурилсан Мэдээллийн технологийн хөндлөнгийн аудитыг хийлгэж байх зохицуулагч байгууллагын шаардлагыг хангав.
 - Төлбөрийн картын аюулгүй байдлын PCIDSS v3.2.1 олон улсын стандартын шаардлагын дагуу жил бүр хийгдэх Self Assessment Questionnaire бөглөн, VISA-д хүргүүлэн баталгаажуулав.
 - Монголбанктай хамтран банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг (ACH) шинэчилж, шинээр багцын гүйлгээний системийг амжилттай нэвтрүүллээ.
 - Харилцагчийн төлбөрийн чадвар, сонирхолд нийцүүлэн сар бүрийн зээлийн төлөлтийг сард тогтмол 2 өдрөөр эргэн төлөлтийн хуваарь хийх боломжийг Үндсэн системд нэвтрүүлэв.
 - Харилцагчийн олон улсын гүйлгээг найдвартай хурдан шуурхай хийх зорилгоор Swift Alliance системийг нэвтрүүлэв.
 - Compass Plus компанийн картын Tranzware системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, Visa enhancement upgrade-н шаардлагыг тасралтгүй оруулах зорилгоор өгөгдлийн сангийн хувилбарыг ахиулж Oracle 12c рүү шилжүүлэх ажлыг 5 сарын хугацаанд амжилттай хийж гүйцэтгэв.
- Үйл ажиллагааны зардлыг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор орон нутаг болон Улаанбаатар хотын салбаруудын ашиглалтын хугацаа дууссан нийт 77 серверүүдийг унтраалаа.
 - Ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төв алба, салбарын нийт 800 орчим компьютерийн техникийн шинэчлэлтийг хийж, нийт 1300 орчим компьютерийн үйлдлийн системийг Windows 10 систем рүү амжилттай шилжүүлэв.
 - Салбар тооцооны төвийн сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах, гаднын хэрэглэгч холбогдож банкны сүлжээнд аюул занал учруулахаас сэргийлэх 802.1x port security шийдлийг нэвтрүүлэв.
 - Банкны үндсэн сүлжээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор үндсэн болон нөөц төв дэх Core Switch төхөөрөмжүүдийг шинэчлэв.
 - Цахим халдлагаас сэргийлэх, хамгаалах тусгай зориулалтын төхөөрөмжийг бүрэн ашиглалтад оруулж хамгаалалтын төрөл тус бүрээр 15000-35000 ялгаатай халдлагаас хамгаалагдах боломжтой болоод байна.

Санхүүгийн үзүүлэлт

Үндсэн суурь орчин:

2019 оны эхний хагаст дотоодын эдийн засаг үргэлжлэн сэргэж, мөнгөний бодлогын хүү тогтвортой хадгалагдсанаар банкны салбарт итгэх иргэдийн итгэл өсөн нэмэгдэж салбарын өсөлтийг хангасан. Гэсэн хэдий ч оны хоёрдугаар хагаст эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж, ДНБ-ий дундаж өсөлт 5 хувиас доошилсон нь 2017 оноос хойших хамгийн бага үзүүлэлт байлаа.

ОУВС-гийн хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байснаас дараагийн үе шат нь хойшлогдож, улмаар Засгийн газар 2.1 их наяд төгрөгийн алдагдалтай буюу 85-аас илүү хувийн донорын дэмжлэгээс хамаарсан төсөв баталсан нь санхүүжилтийн эрсдэлийг улам нэмэгдүүлэв.

2019 оны 7 дугаар сард Монголбанкнаас Базелийн стандарттай нийцүүлэн Зохистой харьцааны шинэчилсэн шалгуур үзүүлэлтүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь арилжааны банкуудын хувьд активын чанар, өөрийн хөрөнгөд улам ихээр анхаарал хандуулах шаардлагатай болов. Бодлогын хүү жилийн 11 хувь хэвээр байв.

Макро эдийн засгийн тодорхой бус байдал, мөн манай улс FATF-ийн саарал жагсаалтад орсон нь нийгмийн итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлж, банкууд валютын нөөцөө нэмэгдүүлэхийн тулд мөчлөгийн үеийн мөнгөний бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь ханшийн тогтвортой байдлыг хангах боловч балансын өртгийг шууд өсгөх үр дагавартай бөгөөд банкуудын хувьд дотоодын нөөцөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай байгаа энэ үед нэмэлт дарамт бий болгосон юм.

Үйл ажиллагааны ерөнхий бодлого:

2019 онд ХасБанк нь эдийн засгийн мөчлөгийн шилжилт, эрх зүйн орчны өөрчлөлтөд нийцүүлэн өөрийн стратеги зорилтуудаа уян хатан байлгаж харилцагч төвтэй хамгийн шилдэг үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилгоо үргэлжлүүлэн баримтлав.

Богино хугацаанд их хэмжээний ашиг олох бус, бизнесийн урт хугацааны үнэ цэнэ, өгөөж дээр төвлөрсөн зорилтот санаачлагуудыг хэрэгжүүлэх стратегийн чиглэлийг сонгож, өсөлт хийх тооцоо төлөвлөгөөгөө шинэчлэв.

Чанартай гүйцэтгэл:

Санхүүгийн тайлант жилийн цэвэр ашиг 8.7 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгийн өгөөж 3.6 хувьтай байгаа нь 2018 оны гүйцэтгэл болох 20.4 тэрбум төгрөгийн цэвэр ашиг, 9.4 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй харьцуулахад даруй буурсан үзүүлэлтүүд бөгөөд энэ нь банкны активын чанарыг бэхжүүлэх зорилгоор байгуулсан тухайлсан сангуудаас үүдэлтэй болно.

Орлогын албан татвар болон зээлийн алдагдлын өмнөх үйл ажиллагааны орлого 27 тэрбум төгрөгөөр өсөж 112 тэрбум төгрөг болсон нь үндсэн орлого буюу цэвэр хүүгийн өгөөж сайжирсантай холбоотой.

Цэвэр хүүгийн орлого 36 хувиар өсөж 23 тэрбум төгрөг болсон бөгөөд үүнд эх үүсвэрийн бүтцийг сайжруулж хүүгийн зардлыг бууруулсан, оны эхний хагаст зээлийн багц өссөн, сүүлийн хагас жилд өндөр өгөөж бүхий зээлд чиглэсэн багцын оновчтой бодлого хэрэгжүүлсэн нь энэхүү үр дүнд хүрэхэд нөлөөлсөн. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого, валютын арилжааны төлөвлөгөө тус бүрийг давуулан биелүүлсэн, дэвшилтэт технологи цахим үйлчилгээг нэвтрүүлснээр үйлчилгээний цар хүрээ тэлснээр 4 тэрбум төгрөгийн бусад орлогыг төвлөрүүлээ.

Тайлангийн жилд зээлийн эрсдэлийн зардал үлэмж өндөр байсан нь эрх зүйн зохицуулагч байгууллагын журамд оруулсан шинэчлэлийн хүрээнд одоогийн эрсдэлийн сангийн хэмжээг өөрчилсөн, мөн СТОУС-ыг хэрэгжүүлсэнтэй холбоотой. Банкны хэмжээний зээлийн алдагдал, эрсдэлийн сангийн зардал тайлант жилд 38 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд үүний 25 тэрбум төгрөг нь сангаас хаасан зээл байв. Энэ өсөлтийн гуравны хоёр нь зээлийн багц, үлдэх хэсэг нь банкны өмчлөлд шилжсэн хөрөнгийг борлуулах, дахин үнэлгээ хийх санд зарцуулав. Эдгээрийн үр дүнд нийт зээлийн багцад чанаргүй зээлийн эзлэх хэмжээ 5.0 хувиас 4.6 хувь болж буурсан нь сүүлийн хоёр жилийн хугацааны хувьд хамгийн сайн үзүүлэлт болов. Нөгөөтээгүүр чанаргүй зээлийн багцын 85.5 хувьд эрсдэлийн сан байгуулж байсныг 89.1 хувь болгож нэмэгдүүлсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байв.

2019 онд Банк үйл ажиллагааны зардлынхаа суурийг бууруулах зорилгоор нийт зардлын төвүүд дээр хэмнэлт хийж зардлаа 6 хувиар бууруулав. Зардлын сахилгыг чанд баримталснаар үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааны зардлын орлогод эзлэх харьцаа 83.9 хувиас 59.9 хувь болж буурсан.

Уян хатан санхүүгийн тэнцэл:

2019 онд Банк нийт активаа 12 хувиар буюу 3,453 тэрбум төгрөгөөр өсгөв. Харилцах, хадгаламжийн дансны өсөлт, харьцангуй хямд зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлснээр энэхүү тэлэлтийг бий болгож ингэснээр системийн хэмжээний дөрөв дэх том банкны байр сууриа бэхжүүлэв. Оны эхний хагаст улс орны эдийн засгийн өсөлттэй уялдаж нийт зээлийн багц өссөн бөгөөд 5 дугаар сард оргил үедээ буюу 2,075 тэрбум төгрөг хүрсэн. Харин жилийн эцсээр 2018 онтой харьцуулахад 6 хувиар буюу 1,828 тэрбум төгрөг болж буурсан.

Нийт зээлийн багцыг бизнесийн чиглэлээр авч үзвэл иргэдийн банк 70 хувь, байгууллагын банк 30 хувийг эзэлсэн бол зээлийн бүтээгдэхүүний хувьд орон сууцны, хадгаламж барьцаалсан, эмэгтэй бизнес эрхлэгчдийн болон ногоон зээлийн нийт 34 тэрбум төгрөгийн багц өссөн байна.

Харилцах, хадгаламжийн багцын хэмжээ хуримтлагдсан хүүг оруулаад 15 хувиар нэмэгдэж 1,830 тэрбум төгрөгт хүрсэн нь ХасБанканд итгэх харилцагчдын итгэлийг улам бататгалаа. Энэ өсөлтийн дийлэнхийг хугацаатай хадгаламж бүрдүүлсэн байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд цөөрч, банк хоорондын гүйлгээ буурснаас төсөл болон дотоодын эх үүсвэр 51 тэрбум төгрөгөөр багассан байна. Гадаад эх үүсвэрийн хэмжээ нийт пассивын 29 хувийг эзэлж байгаа бөгөөд эл эх үүсвэрийг нэр хүнд бүхий олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас татан байршуулсан.

Хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, өндөр өртөгтэй эх үүсвэрийн нөхцөл өөрчлөх зорилгоор зээлийн хүү бага, үр ашигтай нөхцөлтэйгөөр нийт 244 сая ам долларын эх үүсвэрийн 6 гэрээ хэлцэл тухайн жилд хийлээ. Үүнд хамтын санхүүжилтийн 3 хэлцэл нийт 195 сая ам долларын гэрээ байсан бөгөөд оны эцсээр 100 сая ам долларын гэрээний санхүүжилт Банкны дансанд татан төвлөрүүлээгүй байна.

Хөрөнгийн чадавх ба хөрвөх чадвар:

Банк нь зохистой харьцааны шинэчилсэн журмын шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа 2.0 хувиар сайжирч 11.9 хувьд хүрсэн, түүнчлэн хоёрдогч өглөг хэсэгчлэн төлөгдсөн хэдий ч нийт өөрийн хөрөнгийн харьцааг 0.1 хувиар сайжруулж 15.8 хувь болгож өсгөлөө. Өөрийн хөрөнгө сайжирсан нь багцын оновчтой шийдэл, эрсдэлийг бууруулах бодлогын үр дүн юм.

Эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилж буй энэ цаг үед, эх үүсвэрийн төрөлжилтийг хадгалж, зардлаа танаж, ашигт ажиллагааг тогтмол сайжруулснаар хөрвөх чадварын харьцааг 37.4 хувь болгож 7.8 хувиар дээшлүүлсэн нь зохистой харьцааны доод түвшин болох 25 хувиас үнэмлэхүй давсан үзүүлэлт юм.

Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

ХасБанк нь эрсдэлийн удирдлагын сайн засаглалыг бий болгож, эрсдэлийг удирдах арга барилыг тууштай хэрэгжүүлж, харилцагчдын эрх ашгийг хамгаалж, хариуцлагатай зээл олгож, улс орны эдийн засагт хувь нэмрээ оруулсаар ирсэн. Банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээг Банкны бизнесийн стратегитай нийцүүлснээр эрсдэлийн удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг урт хугацаанд нэмэгдүүлдэг.

Банк нь эрсдэлийн удирдлагын соёлыг бэхжүүлж, нийт ажилчдын дунд нэгдсэн ойлголтыг бий болгох, эрсдэлийн соёлыг таниулах, түгээх зорилгоор холбогдох сургалтыг байнга зохион байгуулдаг.

Эрсдэлийн удирдлагын арга барил

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд суурилсан бөгөөд эрсдэлийг хариуцах, хяналт тавих чиг үүргийг дараах байдлаар тодорхойлдог.

- Хамгаалалтын нэгдүгээр бүс нь эрсдэлийг хариуцах эзэн байх бөгөөд эрсдэлийг үнэлэх, хянах, бууруулах чиг үүрэгтэй.
- Хамгаалалтын хоёрдугаар бүс нь эрсдэлийг хянах чиг үүрэгтэй бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, журмыг боловсруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, эрсдэлийн хязгаар үзүүлэлтийг тогтоох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй. Ингэснээрээ Хамгаалалтын хоёрдугаар бүс нь Хамгаалалтын нэгдүгээр бүсийн үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох зааварчилгаагаар хангаж ажилладаг.
- Хамгаалалтын гуравдугаар бүс нь Дотоод аудитын нэгж байх бөгөөд тэдгээр нь Хамгаалалтын нэг, хоёрдугаар бүсийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хараат бус үнэлэлт өгөх чиг үүрэгтэй.

Банкны эрсдэлийн удирдлагын гол чиг үүрэг нь Банкны эрсдэлийн удирдлагын болон хяналтын тогтолцоог зохистой удирдах, боловсронгуй болгох, Хамгаалалтын гурван бүсийн чиг үүргийг улам сайжруулахын зэрэгцээ Банкны бизнесийг дэмжих юм.


Эрсдэлийн удирдлагын засаглал

Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг тогтоох, эрсдэлийг үр дүнтэйгээр удирдах эцсийн хариуцлагыг Банкны Төлөөлөн удирдах зөвлөл хүлээдэг. Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрхийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийг хянаж, эрсдэл нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхэд хяналт тавьж, Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох зөвлөмж хүргүүлэх чиг үүрэгтэй. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны чиг үүргийн нэг хэсэгт Банкны эрсдэлийн удирдлагын арга барил, эрсдэлийн хяналт нь зохистой түвшинд, үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавихаас гадна томоохон дүнтэй зээлийн саналыг шийдвэрлэх асуудлууд багтдаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын бичиг баримтыг баталж, эрсдэлийн удирдлага, эрсдэлийн цар хүрээ, зээлийн багц, стресс тест, сценарийн дүн шинжилгээ зэргийг тусгасан эрсдэлийн удирдлагын тайлан болон Банкны бизнесийн төлөвлөгөө болон зах зээлийн эрсдэлийн дүн шинжилгээний тайланг мөн хэлэлцдэг.

Гүйцэтгэх удирдлагын түвшинд эрсдэлийн удирдлагыг Банкны Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо, Эрсдэл хариуцсан захирал хэрэгжүүлдэг. Банкны хороодын бүтэц, засаглалын дагуу эрсдэлийн удирдлагын бодлого, журмыг батлах, эрсдэлийг удирдах эрх мэдлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх холбогдох хороодод шилжүүлсэн.

Эрсдэлийн Хороод



Хянан нийцүүлэлт

Өнгөрсөн хугацаанд Банкны Хянан нийцүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, Тэнгэр Санхүүгийн Нэгдлээс дэмжлэг хүлээн ажиллаж ирсний үр дүнд Тэнгэр Санхүүгийн нэгдэл болон Банк нь дэлхий стандарт шаардлагатай хөл нийлүүлэн алхаж байна.

Банкнаас Санхүүгийн гэмт хэргийн эрсдэл болон Хянан нийцүүлэлтийн удирдлагын чадавхыг дээшлүүлэхэд оруулсан хөрөнгө оруулалт нь санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах чадварыг эрс нэмэгдүүлж байна.

Монголын эдийн засаг болон банкны өөрчлөгдөж буй олон бэрхшээл, шаардлагуудыг даван туулахуйц хянан нийцүүлэлтийн тогтолцоог амжилттай бий болгож, дэлхийн хэмжээний зохицуулагч болон хууль сахиулах байгууллагуудтай санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хамтын ажиллагааг бий болголоо.

Сүүлийн 2 жилийн хугацаанд банк нь Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг болон хориг арга хэмжээний бодлогын хүрээнд хянан нийцүүлэлтийн үндсэн технологийг амжилттай нэвтрүүлж дууслаа. Түүнчлэн банкны санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийн удирдлагыг өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд ямарваа нэгэн алдаа дутагдал гарах эсэхийг үнэллээ.

Эрсдэлийг илрүүлэх, тайлагнах, хяналтын процессыг илүү чанаржуулах хялбаршуулахад хиймэл оюун ухааны арга хэрэгслийг ашиглаж байна. Ингэснээр өндөр эрсдэл бүхий бүтээгдэхүүн үйлчилгээ болон харилцагч дээр илүү төвлөрөн банкны санхүүгийн гэмт хэрэг болон хянан нийцүүлэлтийн удирдлагын үр дүн болон үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бий болгож байна.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Банк нь зээлийн бодлого, журмыг боловсруулан, зээлийн эрсдэлийг удирдах зохих орчин, нарийвчлан тодорхойлсон процесс, зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагатай хяналтыг бий болгож, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж зээлийн эрсдэлийг удирддаг.

Банкны эрсдэлийн удирдлага нь Банкны зээлийн эрсдэлийг урьдчилан тодорхойлох, эрсдэлийг хэмжих чадварыг сайжруулах зорилгоор олон шинэ санаачилгыг гарган ажилласны нэг нь хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн скоринг, өр төлүүлэлтийн скоринг болон анхаарал татсан дохио илрүүлэх картыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Зах зээлийн болон хөрвөх

чадварын эрсдэлийн удирдлага

2019 онд Банк нь зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийг Банкны хүлээн зөвшөөрөх хэмжээний түвшинд удирдлаа.

Гадаад зах зээл дэх долларын ханшийн өөрчлөлт, худалдааны нөхцөл байдалтай холбоотойгоор 2019 онд төгрөгийн ханш долларын эсрэг 3.4 хувиар суларсан. Банк гадаад валютын позицийг валютын зах зээлийн хөдөлгөөнтэй уялдуулан хянаж, өдрийн гадаад валютын нээлттэй позицийн бодит ашиг, алдагдлыг Хамгийн Их Эрсдэл (Value-At-Risk)-ийн хүрээнд тогтвортой удирдлаа.

Зах зээлд хадгаламжийн хүү буурч байгаа энэ үед хадгаламжийн тогтвортой байдал, Банкны хөрвөх чадварын үзүүлэлтийг өндөр хэвээр хадгаллаа.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

2019 онд Банк нь Хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурласан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан бөгөөд хамгаалалтын хоёрдугаар бүсийн хяналт, заавар зөвлөмжийн дагуу хамгаалалтын нэгдүгээр бүс нь хариуцсан процесст гарч болох үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэй удирдахад чиглэн ажилласан.

Тус ажлын хүрээнд банканд учирч болох үйл ажиллагааны эрсдэлийг зөв тодорхойлох, үнэлэх, саармагжуулахад чиглэсэн жил бүрийн процессын эрсдэлийн үнэлгээг Үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж нь Банкны газар нэгжүүдтэй хамтран амжилттай хийж гүйцэтгэсэн.

Банканд үүссэн болон үүсэж болзошгүй үйл ажиллагааны эрсдэлийн тохиолдлууд, тэдгээрт авсан арга хэмжээ болон Банкны санхүүгийн бус хүлээн зөвшөөрөх хэмжээнд дүн шинжилгээ хийн Үйл ажиллагааны эрсдэлийн хороонд тухай бүр танилцуулж холбогдох хэлэлцүүлэг, шийдвэрүүдийг гаргаж ажилласан.

Банканд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцооны ойлголтыг сайжруулах, эрсдэлийн соёлыг бий болгох зорилгоор Банкны ажилтнуудад дотоод болон зайны сургалт зохион байгуулсан бөгөөд 2019 онд анх удаа нийт ажилтныг хамарсан “Үйл ажиллагааны эрсдэл, Аюулгүй байдал болон Хянан нийцүүлэлт” сэдвээр ерөнхий ойлголт өгөх зорилготой цахим сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Хүний нөөц

Манай банкны хүний нөөцийн бодлого нь олон талт ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх ажил хэрэгч соёлыг дэмжих, хүртээмжтэй ажиллах орчныг бүрдүүлэх, өрсөлдөхүйц хэмжээний цалин хөлс олгох, ажил эрхлэлтийн шударга арга барилаар ажиллах, сурч хөгжих боломжийг ажилтан бүрд олгоход чиглэдэг. Бид төрөл бүрийн нийгмийн хөтөлбөрөөр дамжуулан ажилтнуудынхаа амьдралын чанарыг дээшлүүлэх, ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж ажиллахад тууштай байр суурийг баримталж ирсэн.

2019 оны эцсийн байдлаар ХасБанк 1195 үндсэн ажилтантай байсан ба өмнөх онуудтай харьцуулбал 2018 онд 1270, 2017 онд 1304 ажилтантайгаар тус тус ажилласан. Ажилтнуудын дундаж нас 32.8 бол ХасБанканд ажилласан дундаж хугацаа 6.8 жил байна. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагын дагуу 2019 оны туршид нийт 214 ажилтны ажлын байрыг хүүхэд асрах чөлөөний хугацаанд хадгалсан бөгөөд хүүхэд асрах чөлөөнөөс 86 ажилтан ажилдаа эргэн томилогдсон.



Ажилтны статистик:	
Нийт хөдөлмөрийн гэрээтэй ажилтны тоо	1409
Идэвхтэй ажилтны тоо	1195
Урт хугацааны чөлөө	214
Төв албаны ажилтны тоо	397
УБ хотын салбарын ажилтны тоо	412
Орон нутгийн салбарын ажилтны тоо	386
Дээд болон дунд шатны гүйцэтгэх удирдлага	8+124
Эрэгтэй ажилтан	471
Эмэгтэй ажилтан	724
Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан	8
Сургалтад хамрагдсан ажилтны тоо	1567
Нийт сургалтын хүн/цаг	26,840
Сургалтын хөрөнгө оруулалт	407,600,000
Шинээр ажилд авсан ажилтны тоо	126
Ажил горилогчийн тоо	748
Ажилтны дундаж нас	32.8
Ажилтны дундаж ажилласан хугацаа	6.8

ОНЦЛОХ НЬ

2019 онд тууштай, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд ажилтнуудынхаа харилцагчдад чанартай үйлчилгээг шилдэг шийдлийн хамт үзүүлэх ур чадварыг сайжруулах, бэхжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Түүнчлэн, банкны зээлийн үйл ажиллагаанд оролцогч ажилтнуудын сургалт, хөгжлийн хөтөлбөрт түлхүү анхаарсан. Тухайлбал уул уурхай, ашигт малтмалын төслүүдийн эдийн засгийн үнэлгээг хэрхэн хийх, Зээлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, чанаргүй зээлийн бүтэц зэрэг сэдвээр олон улсын шилдэг туршлага бүхий гаднын сургалтыг зохион байгууллаа.

Дунд шатны менежерүүд, салбарын захирлууд болон чухал албан тушаалын ажилтнуудын бүтцийг олон талт ур чадвар бүхий бүтцээр төрөлжүүлэхэд өндөр ач холбогдол өгсөн ба шинэ залуу чадварлаг ажилтнуудаа залгамжийн хөтөлбөрт хамруулан ур чадварыг нь хөгжүүлэхэд анхаарч ажиллалаа.

ОНОВЧТОЙ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Банкны үйлчилгээний автоматжуулалт болон дижитал банкны үйлчилгээний тэлэлтийн хүрээнд банкны ажилтнуудын бүтээмж нэмэгдэж, зарим чиг үүргүүд автоматчилагдсантай холбоотой банкны төв алба болон салбарын оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болголоо.

Энэхүү зохион байгуулалтын өөрчлөлтийн хүрээнд зарим нэгж, зарим албан тушаалуудын чиг үүргүүд дахин зохион байгуулагдаж, улмаар банкны ажиллах хүчний тоо 6 хувиар буурсан. Шинэчлэгдсэн бүтэц зохион байгуулалт нь банкны ажилтнуудын бүтээмж болон ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зардал бууруулах ач холбогдолтой.

Хүний нөөц



ЦАЛИН ХӨЛС, ХАНГАМЖ

Банк 2018 онд нийт ажилтнуудынхаа үндсэн цалинг шинэчлэгдсэн албан тушаалын зэрэглэл болон цалингийн системийн дагуу дунджаар 10 хувиар нэмэгдүүлсэн бол 2019 онд тухайлсан зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчиллээ.

Шинэчлэгдсэн цалингийн системийн дагуу өндөр ур чадвар бүхий ажилтнууд банкны бизнест оруулж буй хувь нэмрээс хамаарч удирдах албан тушаалтан, дунд түвшний удирдах ажилтантай ижил тэгш хэмжээнд үнэлэгдэх боломжтой болсон.

АЖИЛТНУУДЫН ХӨНГӨЛӨЛТ ХАНГАМЖ, САЙН САЙХАН ОРШИХУЙ

Ажилтнуудынхаа санхүүгийн баталгааг хангах, ажилтныг нэмэлт тэтгэврийн хуримтлалтай болгох зорилготой хувийн тэтгэврийн хөтөлбөрийг 2007 оноос хойш амжилттай хэрэгжүүлж байна. Банкны нийт ажилтнууд тэтгэврийн нэрийн дансны хөтөлбөрт хамрагдсан ба өнгөрөгч 2019 онд Тэтгэврийн нэрийн дансны бодлого журам шинэчлэгдэн урт хугацаат хадгаламжийн хэлбэрт шилжлээ.

Ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг дэмжих, эрүүл мэндийг хамгаалахад зориулж жил бүр гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд хамруулдаг бөгөөд аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах мэдээлэл зөвлөгөө өгөх зорилгоор эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн өдөрлөг, уулзалтуудыг тодорхой давтамжтайгаар зохион байгууллаа.

Ажилтнууддаа олгож буй хөнгөлөлт, хангамжийн нэг хэсэг болох орон сууцны зээл, хэрэглээний зээл, зээлийн карт зэрэг ажилтны зээлийн бодлого, журмыг шинэчилсэн. Түүнчлэн удирдах ажилтнуудыг урт хугацаанд тогтвортой, үр бүтээлтэй ажиллуулах зорилготой Хувьцааны үнэд суурилсан урамшууллын хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлж байна.

ХасБанк нь ажилтнуудынхаа сайн сайхан оршихуйг хангаж ажиллах тууштай байр суурийг хадгалж ирсэн бөгөөд ажилтнуудын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн олон төрлийг нийгмийн хангамжийн хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн. 2019 онд Сайн сайхан оршихуй хөтөлбөрийн хүрээнд сагсан бөмбөгийн ХасЛиг, Үүргэвчтэй хөгжилтэй аялал, ХасСир 6 төрөлт спортын арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 2000 орчим ажилтнууд сайн сайхан оршихуй хөтөлбөрт хамрагдсан байна.

СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Байгууллагын өсөлт, хөгжил нь ажилтнуудын сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдтэй салшгүй уялдаатай байдаг. Тиймээс банк олон төрлийн сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлдэг.

Өнгөрөгч 2019 онд олон улсын түвшний гадаад болон гаднын сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд болон олон улсын мэргэжлийн зэрэг, сертификат олгох хөтөлбөрүүдэд удирдах ажилтнууд болон өндөр ур чадвар бүхий ажилтнуудаа хамруулснаас гадна салбар, тооцооны төвийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд голчлон анхаарч нийт 26.840 хүн/цагийн сургалтыг зохион байгууллаа. (2018 онд 47.324 хүн/цаг 2017 онд 53.178 хүн/цаг).

ИРГЭДИЙН БАНКНЫ СУРГАЛТ:

Иргэдийн Банк тэр дундаа салбар, тооцооны төвийн зээлийн ажилтнуудыг илүү мэргэшүүлэх нь өнгөрөгч онд тэргүүлэх чиглэл байв. Өссөн дүнгээр 5.620 хүн/цагийн сургалтад 260 гаруй ажилтнуудыг хамрууллаа.

Үүнд:

- Жижиг дунд бизнесийн хөгжил болон санхүүжилт, бизнесийн зээлийн судалгаа шинжилгээ, чанаргүй зээлтэй хэрхэн ажиллах талаарх нийт 1.940 хүн/цагийн сургалтад Улаанбаатар хотын салбар, тооцооны төвийн нийт зээлийн мэргэжилтнүүд болон дэд захирлууд хамрагдлаа.
- Зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зээлийн эргэн төлөлтөд хэрхэн хяналт тавих болон чанаргүй зээлийн бүтэц өөрчлөх чиглэлээр 4 удаагийн 232 хүн/цагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн салбарын ажилтнуудыг харилцагчаа таньж мэдэх, чанаргүй зээлтэй ажиллах чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 568 хүн/цагийн сургалтад хамрууллаа.
- Монгол банкнаас зарласан “Хариуцлагатай харилцагч-Хариуцлагатай банк” аяны хүрээнд зохион байгуулсан сургалтуудад салбарын ажилтнуудыг түлхүү хамруулснаар Монголбанкнаас баримталж буй бодлого, түүний өөрчлөлтүүд, цаг үеийн сэдвээр мэдээлэл авах, харилцан туршлага судлах боломжийг олгосон.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

- Уул уурхай, ашигт малтмалын төслүүдийн эдийн засгийн үнэлгээг хэрхэн хийх талаар сургалтыг Монгол Улсын эрдэс баялгийн салбарын институцийн болон хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх төслийн багаас, зохион байгуулсан.
- Зээлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, чанаргүй зээлийн бүтэц өөрчлөх талаар олон улсын тэргүүн туршлагаас хуваалцах семинарыг Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн ТУЗ-ийн гишүүн ноён Анджей Витак зохион байгуулсан.
- Банкны ажилтан бүр аюулгүй байдлын талаар мэдлэгтэй, аюулгүй байдлаас үүдэн учирч болох эрсдэлтэй хэрхэн тэмцэх талаарх Аюулгүй байдлын сургалтыг 2019 онд онлайн хэлбэрээр зохион байгуулсан уг сургалтад банкны нийт ажилтны 90% буюу 1.063 ажилтан амжилттай хамрагдлаа.
- 2016 онд банканд нэвтрүүлсэн Хянан нийцүүлэлтийн цахим сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж, 2019 онд шинээр ажилд орсон 47 ажилтныг хамрууллаа.

МЕНЕЖМЕНТ БОЛОН МАНЛАЙЛЛЫН СУРГАЛТ

- 2019 онд Women's world banking-аас зохион байгуулсан Leadership and Diversity for Innovation Program-д 2 эмэгтэй захирал хамрагдлаа. Уг хөтөлбөрт ХасБанк 2008 оноос хойш хамрагдаж байгаа бөгөөд тус хөтөлбөрт дэлхийн 80 гаруй орны 1000 санхүүгийн байгууллагын эмэгтэй удирдагчид хамрагдаад байгаа юм. Хөтөлбөр нь зайны болон танхимын сургалт хэлбэрээр 8-10 сарын туршид зохион байгуулагддаг, олон улсад тулгарч буй сорилтууд болон олон улсын тэргүүн туршлагуудаас суралцахаас гадна манлайлах, стратегийн түвшний шийдвэр гаргах ур чадвараа сайжруулах, бусдаас суралцах өргөн боломжийг нээж өгдөг өндөр ач холбогдолтой хөтөлбөр юм.
- 2018 онд эхэлсэн “Салбарын захирлын залгамж бэлтгэх хөтөлбөр”-ийг 2019 онд үргэлжлүүлэн зохион байгуулж, 215 цагийн 6 багц хөтөлбөртэйгөөр амжилттай дуусгаж, нийт 11 төгсөгчид батламжийг гардууллаа. Эдгээр төгсөгчдөөс 3 ажилтан салбарын захирлын ажлын байранд томилогдон ажиллаж эхлээд байна.
- Люксембургийн Банкны Холбооны дэргэдэх сургалтын институтээс зохион байгуулсан “Leadership and high performing teams” сургалтад төв албаны 2 хэлтсийн захирлыг хамрууллаа.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГАЛТ

Өнгөрөгч онд 2.320 хүн/цагийн сургалтад мэдээллийн технологийн болон салбарын нийт 110 гаруй ажилтан хамрагдсан. Түүнчлэн банк мэдээллийн технологийн ажилтнуудаа олон улсын мэргэжлийн зэрэг авах, олон улсын түвшинд ажиллах чадвар олгох сургалтуудад хамруулахад голчлон анхаарч ажиллав.

Онцлог сургалтуудыг дурдвал:

- Ази Номхон Далайн Интернэтийн Сүлжээний Мэдээллийн Төвөөс зохион байгуулсан Ази Номхон далайн орнуудын интернет нийлүүлэгч, хэрэглэгчид, эрдэмтэн мэргэдийн чуулга уулзалтын 48 дахь хуралд ХасБанкны мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн хамрагдаж, интернэтийн IPv6 хаягжуулалт, RPKI технологи болон сүлжээний аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын талаарх мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн;
- Нийт найман ажилтан COBIT 5 Foundation болон COBIT 5 Implementation олон улсын онлайн сургалтад амжилттай хамрагдаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификатаа гардан авсан;
- Red Hat System Administrator сургалтад хоёр ажилтан хамрагдсан;
- Oracle Database 12c: Program with PL/SQL болон Oracle 12c Administration сургалтуудад есөн ажилтан хамрагдсан;

МЭРГЭШСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН БАГ

Төслийн удирдлагын хэлтэс нь 2017 оны 7 сард Мэдээлэл технологи, цахим банкны багийн харьяанд байгуулагдсан бөгөөд төслийн удирдлагын олон улсын стандарт, аргачлалд нийцсэн процессыг бий болгож хэвшүүлэхийг зорин ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд 2018 онд мэдээллийн технологийн төслүүдийн хувьд даган мөрдөх PMBOK стандартыг суурь болгосон “Төслийн удирдлагын журам”, “Төслийн өөрчлөлтийн удирдлагын журам”-ыг боловсруулж батлуулсан.

“Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэдэгчлэн төслийн удирдлагын хэлтэс нь нэн тэргүүнд багаараа олон улсын төслийн удирдлагын Project Management Professional (PMP) буюу мэргэшсэн төслийн удирдагчийн зэрэг авах зорилт тавьсныг 2018 онд 100% биелүүлснээр Монгол улсад анх удаа мэргэшсэн төслийн удирдлагын хэлтсийг бий болгож чадсан. Түүнчлэн бид Олон Улсын Төслийн Удирдлагын Институт(PMI)-ийн Монгол дахь салбар болох “Пи Эм Ай Монголиа Чаптер” ТББ-тай хамтран ажиллаж, төслийн удирдлагын хэлтсийн захирал П. Батмөнх нь 2018 оны “Ирээдүйг Бүтээлцэх Төслийн Удирдлага” олон улсын бага хуралд зочин илтгэгчээр, мөн ФМ 98,9-р цацагдах төслийн удирдлагын мэдлэг олгох фм нэвтрүүлэг подкастад зочноор оролцож, банкны төслийн удирдлагын менежментийн талаар танилцууллаа.

2018 онд бид програм хангамжийн төслүүдэд илүүтэй тохирох төслийн удирдлагын Agile - Scrum аргачлалыг бүрэн ашиглан eGateway төслийг хэрэгжүүлсэн бол, 2019 онд төслийн удирдлагын Agile аргачлалуудыг бүрэн судлах, багаасаа хоёр гишүүнийг PMI-Agile Certified Practitioner зэрэгтэй болгох зорилт тавин ажиллаж байна.



Хүний нөөц

АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

Бид ТэнГэр Санхүүгийн Нэгдлийн хэмжээнд ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн засаж сайжруулах шаардлагатай хүчин зүйлсээ тодорхойлдог. 2016 оноос хойш олон улсад өргөн хэрэглэгддэг Gallup Q12 асуулгыг ашиглан ажилтнуудынхаа сэтгэл ханамж, оролцооны түвшинг хэмжиж байгаа бөгөөд 2019 оны хувьд судалгааны бие даасан, мэргэжлийн байгууллагатай хамтран Qualtrics платформыг ашиглан Байгууллагын соёлын судалгааг амжилттай зохион байгууллаа.

ХАСБАНКНЫ ОЛОН ТАЛТ БАЙДАЛ



Макензи Кинг, Эрик Нэвалски, Феликс Тисен – Ази дахь Принстоны төлөөлөгч нарын ХасБанкан дахь ажлын туршлага. 2019 онд ХасБанк нь гадаадын гурван иргэнийг хүлээн авч, ажиллуулж байна. Тэд бол Эрик, Макензи болон Феликс нар юм. Эрик болон Макензи нар нь АНУ-ын “Princeton”-ны Азийн орнуудад хэрэгжүүлж буй туршлага солилцох хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу ХасБанканд ажиллаж байна. ХасБанк болон “Princeton” сургууль нь сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд мэдлэг туршлага, хоёр орны соёл харилцааг дэмжиж зорилгоор хамтран ажиллаж ирсэн билээ. Уг хөтөлбөрт хамрагдаж буй залуусын хувьд тэдгээрийн хүсэл сонирхол болон үр чадварт нийцүүлэн тохирсон байгууллагад дадлага хийх боломжийг олгодог ба байгууллага болон дадлагажиж буй ажилтны харилцан ашигтай туршлага солилцох боломжийг олгодоггоороо онцлог юм.

Феликс-н хувьд Магистрын зэрэг горилогчоор суралцаж байгаа бөгөөд сургалтын хөтөлбөрийн дагуу ХасБанканд дадлагаа хийхээр сонгон ажиллаж байна. Банкны нийгмийн хариуцлага болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хэрэгжүүлж буй санхүүжилт болон төслүүд нь түүний сурлага хүмүүжилд хувь нэмэр оруулна гэж үзсэн тул ХасБанкийг сонгосон.

Эрик болон Феликс нь ХасБанкны Эко Банкны Хэлтэст, уур амьсгалын эсрэг дотоодын болон олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй санхүүжилтийн төсөл, хөтөлбөрүүдийг хариуцан ажилладаг бол Макензигийн хувьд ХасБанкны Бизнес Хөгжлийн Хэлтэст мэргэжилтнээр, Монгол улсын банкны салбарт ашиглагдах санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулах судалгааны ажилд өөрийн хувь нэмрийг оруулахаар тус тус ажиллаж байна.

Эко Банканд ажилласнаар уур амьсгалын эсрэг санхүүжилтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тогтвортой санхүүжилтийн талаар ард иргэдэд туршлага хуримтлуулан ажиллах боломжийг олгож

АЖИЛТНУУДЫН ОРОЛЦОО

Ажилтнуудын оролцоо бол ХасБанк төдийгүй ТэнГэр санхүүгийн нэгдлийн хувьд тэргүүлэх гол чиглэл байсаар ирсэн. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ТэнГэр санхүүгийн нэгдлийн бүх ажилтны баярын хурал, удирдах ажилтнуудын зөвлөгөөн, ажилтнуудын дотоод цахим сүлжээ, тогтмол хийгддэг цахим уулзалт, хурал болон удирдлагын багийн жил бүр Улаанбаатар хотын болон орон нутгийн бүх салбар, тооцооны төвийн тойрон айлчлал, албан томилолт, банкны нэгжүүдийн хурал зөвлөгөөн, стратегийн хэлэлцүүлэг, гүйцэтгэлийн үнэлгээний уулзалтууд зэрэг арга хэмжээнүүдээр дамжуулан ажилтнуудын оролцоог хангаж байна.

байгаа ба дээрх ажлуудын тусламжтайгаар агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарал мөн түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах боломжийг олгох юм.

Харин Бизнес Хөгжлийн Хэлтэст ажилласнаар Монголын банк санхүүгийн салбартай танилцах, тухайн салбарын орчны давуу болон сул талыг олж илрүүлэх түүнээс суралцах боломжийг олгодог. ХасБанкны зүгээс шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажилд олон улсын туршлага, стандартыг нэгтгэх, танилцуулах зэрэг ажлуудыг хийх түүнээс туршлага хуримтлуулах боломжтой болсон.

Эрик нь АНУ-ын Калифорния мужаас гаралтай бөгөөд Georgetown хотын их сургуулийг төгссөн. Монгол улсад хүрэлцэн ирэхийн өмнө San-Francisco хотын санхүүгийн технологи хөгжүүлэгч компанид ажиллаж байсан туршлагатай төдийгүй Тайван улсад Англи хэлний багшаар тус тус ажиллаж байв. Тэрээр явган аялал хийх, хөдөө газар нутгаар аялах сонирхолтой.

Макензи нь АНУ-н Аризона мужаас гаралтай бөгөөд ХасБанканд ажиллахаар ирэхийн өмнө Принстоны их сургуульд амжилттай суралцан эдийн засагч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан. Тэрээр Монголын хэл соёлыг илүүтэй сонирхож түүнтэй танилцах, түүнчлэн аялах сонирхолтой.

Феликс нь одоо 26 настай. ХБНГУ-ын Франкфурт хотод мэндэлсэн. ХасБанканд ажилд орохын өмнө тэрээр Нидерландын Вант улсад 5 жилийн турш суралцсан. Ингэхдээ тус улсын Maastricht-н Их Сургуульд бакалавраар сурч төгссөн бөгөөд Wageningen-н Их Сургуульд “Олон Улсын Хөгжил”-ийн магистрын зэрэг горилогчоор, улс төр болон засаглалын хөгжлийн талаар суралцаж байна. Тэрээр анх 7-н жилийн өмнө Монголд анх хүрэлцэн ирж байсан ба 2013-2014 оны хооронд Германы Konrad-Adenauer-н сангийн Улаанбаатар хотод хэрэгжүүлж байсан төсөлд ажиллаж байсан. Түүний хувьд Монгол орны ард иргэд, нийгэм болон соёлын талаарх өндөр сэтгэгдэл нь түүнийг эргэн ирж ажиллахад нөлөөлжээ.

ХасБанкны Эко Банкны Хэлтэст өөрийн дадлагажих ажлыг хийснээр GCF-тэй хамтран хэрэгжүүлж буй төсөлд оролцох, төслийн удирдлагын чиглэлээр туршлага хуримтлуулах мөн хамгийн чухал нь уур амьсгалын өөрчлөлттэй банкууд хэрхэн тэмцэж байгаа талаар нарийн мэдлэг, туршлагыг олж авах хүсэл сонирхолтой.

ХасБанканд ажиллаж буй эдгээр гурван ажилтны зүгээс сэтгэл өндөр байгаа ба тэд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, төсөл хөтөлбөрүүдэд оролцон ажиллах болон хамт олны халуун дулаан, найрсаг зангийн тусламжтайгаар мартагдахааргүй туршлага хуримтлуулж байна.



АЖИЛТНЫ МЭРГЭЖЛИЙН ӨСӨЛТ БОЛ БИДНИЙ ХӨГЖИЛ

Сэтгэл гаргасан ажил л амжилттай болдог

Бямбасүрэн ДАВААХҮҮ

Салбарын Удирдлагын Хэлтэс, Бүсийн захирал

Миний бие ХасБанканд 13 дахь жилдээ ажиллаж байна. Анх 2006 онд МУИСургууль төгсөөд орон нутагт очиж ажиллахаар шийдэж байлаа. Энэ шийдвэр нь Улаанбаатар хотод амьдарч байсан аав, ээжийн зөвшөөрөл, манайд амьдарч ажил хий гэж дуудсан авга ах, эгчийн туслалцаа, бүгдээрээ төрөлх нутагтаа ажиллаж амьдаръя гэж уриалсан найз нөхдийн ятгалгаар баталгаажиж хэрэгжсэн юм. Анх багшийн ажил хийх гэж Завхан аймаг руу явсан надад ХасБанканд ажилтан авна гэсэн зар онцгой сонин санагдаж байсан. Яагаад ХасБанк тэгж их анхаарал татаж байсан вэ гэхээр аав ээж маань ХасБанкны харилцагч байсан. Намайг, миний эгч, дүү нарыг бүгдийг дээд боловсролтой болоход ХасБанкны зээлийн үйлчилгээ маш том дэмжлэг болж байсан. Мөн оюутны хэрэгцээний мөнгийг ХасБанкаар л шилжүүлдэг байлаа. Өөр банк гэж бараг сайн мэддэггүй байсны дээр ХасБанкны ажилтан ах эгч нар, бидний амьдралд өгсөн ашиг тус нь энэ банканд ажиллах нууцхан хүслийг төрүүлж байжээ. Тийм учраас би өргөдөл өгч ярилцлагад орсон. Суманд төрж өссөн, мал аж ахуй, орон нутгийн амьдралыг илүү мэднэ гэдэг утгаар нь ч юм уу намайг ажилд авч Хөдөөгийн зээлийн мэргэжилтэн гэдэг албан тушаалд ажиллуулж эхэлсэн.

Аймгийн төвөөс сумд руу явж зээл судлан газар дээр нь олгодог, эргэн төлөлтөө цуглуулдаг энэ ажлыг манай банк л хийдэг, би бол тэр үеийн зуу, зуун залуучуудын нэг байсан. Мөн сумдын хадгаламж зээлийн хоршоог дэмжиж тэдэнд франчайзийн үйлчилгээг үзүүлж өмнө нь хэзээ ч байгаагүй өвөрмөц боловч маш том ажлыг хариуцлагатай хашиж явсандаа баяртай байдаг. Энэ бүхэн мэдлэг туршлага өгч ажиллах эрч хүчийг нэмэгдүүлж тогтвортой, зорилготой, зоригтой ажиллах суурь болсон гэж хувьдаа үздэг.

ХасБанкны салбартаа хөдөөгийн зээлийн мэргэжилтэн, франчайзийн менежер, харилцагчийн мэргэжилтэн, бизнес борлуулалтын менежерийн ажлыг хийж байлаа. 2010 онд салбар, тооцооны төвийн захирлын ажлын гараагаа эхлэн нэр хүндтэй, өндөр үр чадвар, мэдлэг шаардсан, хариуцлагатай ажлыг хийх болсон. Энэ нь маш том сорилт болж байлаа. Энэ сорилтыг үе үеийн туршлагатай салбарын захирлууд, хамт олны нэгдмэл санаа, удирдлагуудын үнэтэй сургамж,



ЧАДВАРЛАГ ШИНЭ АЖИЛТНУУДЫГ ДЭМЖИХ БИДНИЙ СОЁЛ

Өөрчлөлт, сорилтын цаана боломж байдаг

Батболдын ХУНШАГАЙ

Ривер Стрийт Тооцооны Төв, Захирал

Сайн байна уу, Намайг Хуншагай гэдэг. Миний бие МУИС-Бизнесийн сургуульд “Банкны менежмент” мэргэжлээр суралцаж төгссөн. Банкны салбарт 2012 оноос хойш, ХасБанканд 2016.09 сараас хойш ажиллаж байна.

1. Өөрчлөлтийг эерэгээр хүлээж авах, 2. Тав тухтай бүсээсээ гарч чадахгүй зүйлээ хийж үзэх, 3. Амжилттай хүмүүстэй танилцаж, хамтран ажиллах хандлагатай байх нь хувь хүн төдийгүй байгууллагын тогтвортой амжилтын гол түлхүүр үзүүлэлт гэж би боддог. ХасБанканд Зээлийн эрсдэлийн ахлах шинжээчээр шилжин ажиллах болсон нь миний хувьд маш том өөрчлөлт, бас боломж байсан. ХасБанканд орохоос өмнө дөрвөн жил нэг байгууллагад ажилласан тул эхний гурван сард шинэ байгууллага, шинэ соёл, шинэ хамт олондоо дасахад амар байгаагүй. Хамгийн эхний шок бол бүгд намайг мэдэхгүй, яг л их сургуулиа төгсөөд ажилд орж байсан шиг дахин шинэ ажилтан болсон мэдрэмж байсан. Гэвч шинэ хамт олны найрсаг уур амьсгал болон дэмжлэгт хурдан дассан.

2017 онд үндсэн ажил үүргээс гадна Активын чанарын үнэлгээний багт орж ажилласан. 2017 оны эцэст үр дүн гарахад ХасБанк хамгийн сайн үзүүлэлттэй гарсан. Энэ бүгдээс ХасБанкны эрхэм зорилгод бичигдсэн “Эрүүл ашиг” ямар их чухал болохыг ойлгож, ухамсарлаж бас ХасБанкны ажилтны хувьд ХасБанкаар илүү их бахархах сэтгэл төрсөн. 2017 оны 12 сард хамт олон, удирдлагын баг хичээл зүтгэлийг минь өндрөөр үнэлэн салбарын захирлаар томилсон нь миний хувьд дахин том боломж бас сорилт болсон. Чин үнэнийг хэлэхэд ажилтан байхад удирдлагын гүйцэтгэж буй ажил хянах, чиглүүлэх гэх мэт амархан мэт харагддаг байсан боловч эсэргээрээ хамгийн өндөр ёс зүй, харилцааны үр чадвар, манлайллыг шаарддаг хүнд ажил болохыг ойлгосон. Битгий хоцор биш өөрөө хоцрохгүй байх, борлуулалт хий бус өөрөө манлайлан борлуулах, зөвхөн ажил бус урам зориг, сайшаалын

зөвлөгөө, төв албаны сургалт, дэмжлэгээр хийж байсан. Хамгийн гол нь бидэнд итгэдэг харилцагчид, түншүүдийн хамтын ажиллагаагаар өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлж, үр дүнтэй ажилласныг дурдах нь зүйн хэрэг. 2010-2018 онд орон нутаг, Улаанбаатар хотын 5 салбар, тооцооны төвийн захирлаар ажиллуулж өндөр итгэл хүлээлгэсэн удирдлагуудынхаа итгэлийг алдахгүй байхын тулд өдөр бүр хичээдэг байлаа.

Харин энэ хугацаанд намайг үргэлж дэмжиж, зөвхөн ажилдаа санаа зовох зүйлгүй, бүх анхаарлаа хандуулан, хамгийн сайнаар хийх тэр их сэтгэл зүй, эрч хүч, боломжоор хангаж, гэр бүл хэмээх энэ амьдралын минь хамгийн чухал зүйлийг минь хамтдаа бүтээлцэж, найдвартай ар тал маань байж чадсан, одоо ч тийм байгаа ханьдаа би талархаад барамгүй.

2018 оноос банкныхаа төв албанд ажиллах болсноор би өөрийгөө илүү шинэ зүйлд сорих, дайчлах боломж гэж харж яг л шинэ ажилтнаар орж ирж байгаа мэт тийм их урам зоригтойгоор харж байлаа. Ажилд ороод нэг жил ч болоогүй байхдаа дүрэм журмаа бүтэн судлаагүй, өөрийн буруутай байдлаасаа болж сахилгын шийтгэл авч билээ, юу ч хийж бүтээгээгүй байж шийтгэл авах гэдэг бол шантрах маш том шалтаг болсон, зүгээр л яваад өгмөөр бас гэртээ хармаар санагдах тэр сэтгэл зүйг би давж, ажлаа үргэлжлүүлэн хийж илүү хичээж ажилласан.

Надад тусалдаг, дэмждэг хамт олон, бидэнд итгэдэг харилцагчид, миний хийж дуусаагүй ажлууд, бидний зорилго, энэ том байгууллагын соёл миний дотор маш том байр суурийг эзэлсэн байсан. 1 жилийн дараа “Франчайзийн шилдэг менежер” гэсэн гүйцэтгэх захирал, ерөнхий захирлын гарын үсэгтэй өргөмжлөл авч, Мөн 2018 онд ХасБанкныхаа “Шилдэг ажилтан” болсноор тэр үед ажлаас гараагүйгээ зөв байсан гэдгийг өөртөө нотолсондоо маш их баярлаж байлаа.

Банкны ажилд нэг хүний ажил гэж байдаггүй, бүгд хамтын ажиллагаа, багийн ажиллагаагаар хийгддэг гэдгийг маш сайн ойлгож мэдэрсэн. ХасБанкны мэргэжлийн, эрч хүчтэй залуустай мөр зэрэгцэн ажиллаж байгаа нь миний энэ насны амьдралын хамгийн том бахархал байх болно. Бидэнд хийсэн ажил асар их боловч хийх ажил түүнээс их байгаа. Бид мянга мянган харилцагчийнхаа өмнө ухарч болохгүй үүрэг хүлээсэн.

үгийг ажилтнууддаа харамгүй хэлж, урамшуулж байх нь хэчнээн чухал болохыг илүү сайн ойлгосон.

Харилцагчид банкийг тухайн банкны салбарын баг хамт олны харилцааны үр чадвар, үзүүлж буй үйлчилгээний чанараар нь дүгнэдэг гэж би боддог. Ийм ч учраас хамт олон, удирдлагын багийнхаа итгэлийг алдахгүйн тулд багаараа хичээн ажилласны үр дүнд зээлийн багцын гүйцэтгэлээ 375.6%-иар, эх үүсвэрийн гүйцэтгэлээ 254.2%-аа биелүүлж, нийт салбар, тооцооны төвүүдээ тэргүүлэн ажиллаж, ХасБанкны 2018 оны “Шилдэг салбар” болсон.

Гэвч манай хамт олон бие биедээ энэ бол эхлэл гэж хэлсэн юм. Бид сэтгэл ханаж амжилтад хүрсэн цэгээсээ уруудаж эхлэхийг хүсээгүй. Бид оргилуун дарс шиг гэнэт тэсэрч гарч ирээд үүн шигээ гэнэт алга болохыг хүсээгүй. Бид улам хичээсэн, бид харилцагчдынхаа хэрэгцээ, шаардлага, асуудлыг улам сайн шийдвэрлэж өгөхөөр ажилласан. Үүний үр дүнд бид 2019 онд амжилтаа дахин давтаж ХасБанкны 2019 оны “Шилдэг салбар” болсон.

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчдадаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг санал болгон ажиллахад маш сайхан байдаг. Ж.нь Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн хөнгөлөлттэй зээл, хүлэмжийн хийг бууруулах Эко бизнесийн зээл, Монгол улсын ирээдүй болсон хүүхдүүдээ дэмжсэн Ирээдүйн саятан хадгаламж гэх мэт...

Миний хувьд ХасБанканд ажиллаж эхэлснээс хойш маш их мэдлэг, мэдээлэл, үр чадварыг сурч байнгын өсөж дэвжсээр байгаадаа маш их баяртай байдаг. ХасБанкны нийт хамт олон болон харилцагчид, Ривер стрийт тооцооны төвийн хамт олон (Хувийн банкир Л.Солонго, Б.Мөнх-Орчлон, П.Оюунтулга, Е.Золбоо, Э.Оюун-Ухаан, Хянагч Нябо В.Дэлгэр, Г.Алтанцэцэг ХҮМ Т.Мөнхтуул, Т.Амаржаргал, Ч.Оюун-Эрдэнэ) нартаа чин сэтгэлээсээ баярлалаа.

Дотоод аудит



Дотоод аудит нь группийн дотоод хяналтын тогтолцооны хамгаалалтын гуравдугаар бүс бөгөөд хараат бус, бие даасан үйл ажиллагааг явуулахдаа олон улсын шилдэг туршлага, мэргэжлийн стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аргачлалыг үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд банкны бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг үнэлсний үндсэн дээр аудитын төлөвлөгөө боловсруулан гаргадаг.

Дотоод аудитын газар нь аудитын арга аргачлалыг тогтмол сайжруулан, шинэчилж олон улсын шилдэг туршлагатай хөл нийлүүлэн ажиллахыг зорилго болгодог. Энэ жил бид дата шинжилгээг аудитын үйл ажиллагаанд түлхүү хэрэгжүүлэхээр анхааран ажиллаж технологид суурилсан тасралтгүй хяналт болон зайны аудитыг хэрэгжүүлэх болсон. Ингэснээр аудитын нөөцийг зохистой удирдах, болзошгүй эрсдэлийг цаг алдалгүй илрүүлэн сэргийлэх болон алдаа зөрчлийг залруулах боломжтой болсон. Дотоод аудит нь тусгайлан аудитын хэрэгслүүд ашиглан нийцлийн болон ашиглангийн шинжтэй үйлдлийг илрүүлэн ажиллаж байна. Мөн энэ онд бид хамгаалалтын нэг дүгээр бүсийн хяналтыг улам сайжруулах үүднээс автоматчилагдсан хэрэгслүүдийг боловсруулан ашиглаж, алдаа илрүүлэх болон мэдээллийн чанартай тайлангуудыг нийт салбаруудад сарын давтамжтай хүргүүлж эхэлсэн.

2019 онд бид Улаанбаатар хотын 2 ХАБ салбар буюу хотын 8 салбар тооцооны төв, орон нутгийн 18 салбар тооцооны төв болон зайнаас 2 салбарыг аудиталсан. Учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон, үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэхийн тулд бүтээгдэхүүн, үйлчилгээ дэх системийн хяналт гэх сэдэвчилсэн аудитыг хийсэн. Эрсдэлд суурилсан төлөвлөгөөний хүрээнд 3 процессын аудитыг хийсэн.

Түүнчлэн мэдээллийн технологийн аудитын хүрээнд эрсдэлийн үнэлгээнд суурилан Өөрчлөлтийн удирдлага, тасралтгүй байдлын удирдлага, мэдээллийн технологийн эрсдэл, мөн мэдээллийн технологийн хянах, үнэлэх аудитуудыг хийсэн. Мэдээллийн технологийн аудитын төлөвлөгөө болон дотоод нөөцийг байгууллагын стратеги, зохицуулагч байгууллагын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын уламжлалт арга барилыг орчин үеийн шинэлэг аргачлалаар баяжуулахын зэрэгцээ аудитын мөрөөр өгөх зөвлөмжийн агуулгыг банкны үйл ажиллагаанд үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарлаа түлхүү хандуулж байна. Эдгээр зөвлөмжүүд нь банкны стратеги зорилгод хүрэхэд чухал хувь нэмэр бүхий засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын зохистой тогтолцоог дэмжихэд чиглэдэг. Аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг сар бүр хянаж байна.

Тэргүүлэх туршлагыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дотоод аудит нь өөрсдийн үйл ажиллагааг Дотоод аудиторуудын Олон Улсын Институт (IIA)-ээс боловсруулсан чанарын баталгаажуулалт, сайжруулалтын хөтөлбөр (QAIP)-тэй нийцүүлэн 4 дэх жилдээ үнэлж байна. Аудитын чанарын үнэлгээг аудит тус бүрээр үнэлдэг ба дотоод аудитын өөрийн үнэлгээг жилд нэг удаа үнэлж хэвшээд байна.

Түүнчлэн бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэшсэн боловсон хүчин бэлдэх зорилготой ажилладаг ба энэ ажлын хүрээнд CIA болон CISA зэрэгтэй аудиторуудтай болсон. Мөн бид аудиторуудаа дотоодын болон олон улсын сургалт, семинарт тогтмол хамруулж аудиторуудын чадвар, чадамжийг бэхжүүлж байна.

